



ШҮҮХИЙН СУРГАЛТ,  
СУДАЛГАА,  
МЭДЭЭЛЛИЙН ХҮРЭЭЛЭН

**ТЭЭВЭР ЗУУЧИЙН ГЭРЭЭНИЙ  
ОЙЛГОЛТ БА ГЭРЭЭНИЙ ЭРХ  
ЗҮЙН ХАРИЛЦААТАЙ ХОЛБООТОЙ  
ОНЦЛОГ ЗОХИЦУУЛАЛТЫН  
ТАЛААРХ СУДАЛГАА**

СУДАЛГААНЫ САН: ИХ/00/2023/08/31

ШҮҮХИЙН СУДАЛГААНЫ ТӨВ  
2023.07.07



ТОВЬЁГ

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ .....	3
УДИРТГАЛ .....	4
Судлах зүйл .....	4
Судалгааны хамрах хүрээ .....	4
Судалгааны арга зүй .....	4
Судалгааны бүтэц.....	4
НЭГ. ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА.....	5
1.1 ТЭЭВЭРЛЭЛТИЙН ГЭРЭЭ, ТЭЭВЭР ЗУУЧИЙН ГЭРЭЭ, КОМИССЫН ГЭРЭЭ, ХУДАЛДААНЫ ТӨЛӨӨЛӨГЧ БА ХУДАЛДААНЫ ЗУУЧЛАГЧИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ, ЯЛГАА (ТҮҮНИЙ ЭРХ, ҮҮРЭГ) .....	5
1.1.1 ХБНГУ.....	5
1.1.2. БНФУ .....	8
1.1.3. ЯПОН УЛС.....	10
1.2. АВТО ЗАМ, ТӨМӨР ЗАМ, АГААРЫН ТЭЭВРИЙН ЯЛГААТАЙ ОНЦЛОГ ЗОХИЦУУЛАЛТ.....	15
1.2.1. ХБНГУ.....	15
1.2.2. БНФУ .....	17
1.2.3. ЯПОН УЛС.....	17
1.3. ГЭРЭЭНИЙ ҮҮРЭГТЭЙ ХОЛБООТОЙГООР АЧАА, БАРААНД УЧИРСАН ХОХИРОЛ, ГЭМ ХОРЫГ ШААРДАХ, ТҮҮНД ХАМААРАХ ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА .....	17
1.3.1 ХБНГУ.....	17
1.3.2. БНФУ .....	20
1.3.3. ЯПОН УЛС.....	20
1.4.1. ХБНГУ.....	21
1.4.2. БНФУ .....	23
1.4.3. ЯПОН УЛС.....	26
ДҮГНЭЛТ.....	27
НОМ ЗҮЙ .....	30



## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

**ААН**

**БНФУ**

**УДШ**

**ХБНГУ**

**ШССМХ**

Аж ахуйн нэгж

Бүгд Найрамдах Франц Улс

Улсын дээд шүүх

Холбооны Бүгд Найрамдах Герман Улс

Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэн



## УДИРТГАЛ

### Судлах зүйл

Судалгааны ажлын хүрээнд тээвэрлэлтийн гэрээ, тээвэр зуучийн гэрээ, комиссын гэрээ, худалдааны төлөөлөгч ба худалдааны зуучлагчийн тухай ойлголт ялгаа, тэдгээрийн эрх, үүрэг, тээвэрлэлтийг гүйцэтгэж буй арга хэлбэр буюу авто зам, төмөр зам, агаарын тээврээс хамаарсан онцлог зохицуулалт байгаа эсэх, гэрээний үүрэгтэй холбоотойгоор ачаа бараанд учирсан хохирол, гэм хорыг шаардах эрх, гэрээний үүрэгтэй холбоотой харилцаанаас үүсэх нэмэлт үүрэг (мэдээлэл өгөх) гэсэн 4 үндсэн асуудлын хүрээнд энэхүү судалгааны ажлыг гүйцэтгэлээ.

### Судалгааны хамрах хүрээ

Тээвэр зуучийн гэрээний ойлголт ба гэрээний эрх зүйн харилцаатай холбоотой онцлог зохицуулалтын талаарх судалгааг хийж гүйцэтгэхдээ ХБНГУ, БНФУ болон Япон Улсыг хамруулан тэдгээрийн эрх зүйн зохицуулалт, тээврийн гэрээний стандарт, олон улсын гэрээ, конвенцод уг ойлголтыг онолын үүднээс хэрхэн авч үзэж буй талаар судалсан.

### Судалгааны арга зүй

Судалгааг хийж гүйцэтгэхдээ харьцуулан судлах, нэгтгэн дүгнэх арга зүйг ашигласан.

### Судалгааны бүтэц

Тус судалгаа Харьцуулсан судалгаа, Дүгнэлт, Ном зүй гэсэн хэсгээс бүрдэнэ.



## НЭГ. ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

### 1.1.ТЭЭВЭРЛЭЛТИЙН ГЭРЭЭ, ТЭЭВЭР ЗУУЧИЙН ГЭРЭЭ, КОМИССЫН ГЭРЭЭ, ХУДАЛДААНЫ ТӨЛӨӨЛӨГЧ БА ХУДАЛДААНЫ ЗУУЧЛАГЧИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ, ЯЛГАА (ТҮҮНИЙ ЭРХ, ҮҮРЭГ)

#### 1.1.1 ХБНГУ

ХБНГУ нь арилжааны хэлцэл болох тээвэрлэлтийн, илгээмжийн, комиссын, хадгалалтын гэрээ мөн худалдааны төлөөлөгч, худалдааны зуучлагчийн харилцааг Арилжааны хуулиар (1897, Handelsgesetzbuch) зохицуулдаг.

Тус хуулийн дөрөвдүгээр номын (*Viertes buch*) дөрөвдүгээр хэсэгт тээвэрлэлтийн гэрээ, тав дах хэсэгт илгээмжийн/тээвэр зуучийн гэрээ, зургаа дах хэсэгт хадгалалтын гэрээ, нэгдүгээр номын долоодугаар хэсэгт худалдааны төлөөлөгч, наймдугаар хэсэгт худалдааны зуучлагчийн харилцааг тус тус зохицуулжээ.

<b>Тээвэрлэлтийн гэрээ</b>	<p>Арилжааны хуулийн §407-452 дугаар зүйлд тээвэрлэлтийн гэрээний харилцааг зохицуулжээ. Үүнд тээвэрлэлт (§407-450), нүүлгэн шилжүүлэх тээвэрлэлт (§451), олон төрлийн тээврийн хэрэгсэл ашиглан тээвэрлэх (§452) харилцаа багтсан байна.</p> <p>407 дугаар зүйлд заасны дагуу <i>тээвэрлэлтийн гэрээгээр</i> тээвэрлэгч барааг тохирсон газарт хүргэж, тэнд хүлээн авагчид хүлээлгэн өгөх үүрэгтэй<sup>1</sup> бол ачаа илгээгч нь хэлэлцэн тохирсон тээврийн хөлсийг төлөх үүрэгтэй.<sup>2</sup> Энэхүү тээвэрлэлтийн зохицуулалт нь а) ачааг газраар, дотоодын усан замаар эсвэл агаарын хөлгөөр тээвэрлэх<sup>3</sup> б) мөн тээвэрлэлт нь тухайн ААН-ийн аж ахуйн үйл ажиллагаанд хамаарч байх нөхцөлд<sup>4</sup> хамаарахаар заасан байна.</p> <p>451 дүгээр зүйлд зааснаар ачааг тээвэрлэх гэрээний гол нөхцөл нь нүүдэл хийх зорилгоор ачаа тээвэрлэх бол<sup>5</sup> үүнийг <i>нүүлгэх гэрээ</i> гэж нэрлэдэг ба тээвэрлэгч нь тавилгыг задлах, угсрах болон нүүдлийн ачааг ачих, буулгах үүрэгтэй<sup>6</sup> ба хэрэв илгээгч нь хэрэглэгч бол тээвэрлэгч нь нүүдэлтэй холбоотой бусад үйлчилгээг, тухайлбал савлах, баглах, боох болон ачааны тэмдэглэгээг хийх үүрэг хүлээнэ.<sup>7</sup></p> <p>452 дугаар зүйлд <i>олон төрлийн тээврийн хэрэгслээр ачаа тээвэрлэх гэрээг</i> зохицуулжээ. Дэлгэрүүлбэл, нэгдсэн нэг тээвэрлэлтийн гэрээний үндсэн дээр тээвэрлэлтийг нь хэд хэдэн төрлийн тээврийн хэрэгсэл ашиглан хийж байгаа бөгөөд нэг тээврийн хэсэг бүрд өөр өөр тээврийн хэрэгсэл ашиглах явдал нь тус бүрнээ бие даасан гэрээний зүйл болох боломжтой бөгөөд эдгээрээс дор хаяж хоёр нь өөр улсын хуульд захирагдах нөхцөлд энэхүү гэрээгээр зохицуулагдана.<sup>8</sup></p>
----------------------------	---

<sup>1</sup> Handelsgesetzbuch §407(1), <https://www.gesetze-im-internet.de/hgb/BJNR002190897.html#BJNR002190897BJNG000200300>, (Сүүлд үзсэн: 2023.06.28).

<sup>2</sup> *Ibid* (2).

<sup>3</sup> *Ibid* 1(3).

<sup>4</sup> *Ibid* 2.

<sup>5</sup> *Ibid* §451.

<sup>6</sup> *Ibid* (1) §451a.

<sup>7</sup> *Ibid*. (2)

<sup>8</sup> *Ibid*. §452



<p><b>Илгээмжийн/Тээвэр зуучийн гэрээ</b></p>	<p>Арилжааны хуулийн §453-466 дугаар зүйлд <i>илгээмжийн гэрээ</i> буюу <i>тээвэр зуучийн гэрээний</i> харилцааг зохицуулжээ. Илгээмжийн гэрээгээр тээвэр зуучийн үйлчилгээ эрхлэгч нь барааг илгээх үүрэгтэй<sup>9</sup> бол илгээгч нь хэлэлцэн тохирсон хөлсийг төлөх үүрэг хүлээнэ.<sup>10</sup></p>
<p><b>Комиссын гэрээ</b></p>	<p>Арилжааны хуулийн §383-406 дугаар зүйлд <i>комиссын гэрээний</i> харилцааг зохицуулсан ба комисс эрхлэгч гэдэг нь өөрийн нэрээр үйлчлүүлэгчийн зардлаар бараа, үнэт цаасыг мэргэжлийн үйл ажиллагааны хүрээнд худалдан авч эсвэл худалдаж буй этгээд юм.<sup>11</sup></p>
<p><b>Худалдааны төлөөлөгч ба Худалдааны зуучлагч</b></p>	<p>Арилжааны хуулийн нэгдүгээр номын долоодугаар хэсэгт худалдааны төлөөлөгч, наймдугаар хэсэгт худалдааны зуучлагчийн харилцааг тус тус зохицуулсан байна. <i>Худалдааны төлөөлөгчийг</i> §84- 92 дугаар зүйлд зохицуулсан бөгөөд худалдааны төлөөлөгч гэдэг нь бие даан аж ахуйн үйл ажиллагаа эрхэлдэг, өөр нэг бизнес эрхлэгчийн даалгавраар түүний хэлцэлд зуучлах эсвэл түүний нэрээр хэлцэл хийх эрх бүхий этгээд юм.<sup>12</sup> Бие даан аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх гэдэгт өөрийн хийх ажлыг өөрөө зохион байгуулж, ажлын цагаа өөрөө тодорхойлох эрхтэй байхыг ойлгоно. Харин <i>худалдааны зуучлагчийн</i> зохицуулалтыг §93-104 дүгээр зүйлд заасан ба худалдааны зуучлагч гэдэгт байнгын гэрээ байгуулснаас бусад тохиолдолд бараа, үнэт цаас худалдан авах, худалдах ажил, даатгалын үйлчилгээ, барааг тээвэрлэх, усан онгоц түрээслэх эсвэл бусад хэлбэрээр худалдааны эрх зүйн харилцаанд бусдын өмнөөс оролцож буй этгээдийг ойлгоно.<sup>13</sup></p>

<sup>9</sup> Ibid (1) §453.

<sup>10</sup> Ibid (2).

<sup>11</sup> Ibid (1) §383.

<sup>12</sup> Ibid (1) §84.

<sup>13</sup> Ibid (1) §93.



## Тээвэрлэгч, тээвэр зууч нарын гэрээгээр хүлээх эрх, үүрэг

Тээвэрлэлтийн гэрээ	
<p><u>Тээвэрлэгчийн эрх:</u></p> <ul style="list-style-type: none"> <li>• Барааны бохир жин эсвэл өөр байдлаар тэмдэглэсэн тоо хэмжээ, ачааны агууламжийг тээвэрлэгч үзэж шалгаад үр дүнг хоёр талын гарын үсэг зурсан гэрээнд тэмдэглэсэн бол энэ нь барааны жин, тоо хэмжээ, агууламж нь дагалдах бичигтэй дүйж байсан гэсэн таамаглалын үндэслэл болно. Ачаа тээвэрлэгч нь илгээгчийн шаардлагаар эсвэл түүнд ийнхүү шалгах хангалттай хэрэгсэл бий нөхцөлд жин, тоо хэмжээ, агуулгыг <b>шалгах үүрэгтэй</b> ба тээвэрлэгч нь шалгалт хийхэд гарсан <b>зардлаа нөхөн төлүүлэх эрхтэй</b>.<sup>14</sup></li> </ul> <p>Тээвэрлэгч нь барааг хүлээн авах үед аюултай нөхцөл байдлын талаар мэдээгүй эсвэл энэ талаар мэдэгдэл хүлээн аваагүй бол илгээгчид хохирлыг нөхөн төлөхгүйгээр аюултай барааг буулгах, хадгалах, буцааж тээвэрлэх, шаардлагатай бол устгах эсвэл аюулгүй болгох мөн илгээгчээс эдгээр арга хэмжээг авахад гарсан зайлшгүй <b>зардлыг гаргуулах эрхтэй</b>.<sup>15</sup></p> <ul style="list-style-type: none"> <li>• Тээвэрлэгч нь гэрээнд заасан эсвэл түүний эрсдэлийн хүрээнд үл хамаарах шалтгаанаар ачих ба буулгах хугацаанаас илүү урт хугацаагаар хүлээх болсон нөхцөлд тохирох хөлс (<b>зогсолтын хөлс</b>) <b>шаардах эрхтэй</b>.<sup>16</sup></li> <li>• Илгээгч гэрээг цуцалсан нөхцөлд тээвэрлэгч нь тохирсон хөлс, зогсолтын хөлс, гэрээг цуцалснаар хэмнэсэн зардал болон бусад хэлбэрээр олсон эсвэл олж болох байсан хэсгийг хасаад гарсан зардлыг нөхөн төлөх, эсвэл тохиролцсон ачааны хөлсний гуравны нэгийг <b>шаардах эрхтэй</b>.<sup>17</sup></li> <li>• Тээвэрлэгчийн зүгээс тээвэрлэлтийн гэрээнээс үүдэлтэй бүх шаардах эрхийн хувьд тээвэрлүүлэхээр зөвшөөрөл өгсөн илгээгч эсвэл гуравдагч этгээдийн <b>барааг барьцаалах эрхтэй</b>.<sup>18</sup></li> </ul>	<p><u>Тээвэрлэгчийн үүрэг:</u></p> <ul style="list-style-type: none"> <li>• Барааг тохирсон газарт хүргэж, хүлээн авагчид <b>хүлээлгэн өгөх үүрэгтэй</b>.<sup>19</sup></li> <li>• Ачааг тохиролцсон хугацаанд, хугацаа тохиролцоогүй бол нөхцөл байдлыг харгалзан тээвэрлэгчийн ачааг тээвэрлэх <b>үндэслэл бүхий хугацаанд хүлээлгэж өгнө</b>.</li> <li>• Тээвэрлэгч нь тээвэрлэлтийн үйл ажиллагаанд нийцэх байдлаар ачааг ачна.<sup>20</sup></li> <li>• Тээвэрлэгч нь түүний аж ахуйн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөхгүй, бусад илгээмжийг илгээгч эсвэл хүлээн авагчид хохирол учрахааргүй бол илгээгчээс олгосон <b>хожим зааврыг мөрдлөг болгох үүрэгтэй</b>.<sup>21</sup></li> </ul> <p>Тээвэрлэгч түүнд өгсөн уг зааврыг мөрдөхөөргүй бол уг заавар өгсөн этгээдэд нэн даруй <b>мэдэгдэх үүрэгтэй</b>.<sup>22</sup></p>
<b>Илгээмжийн/Тээвэр зуучийн гэрээ</b>	

<sup>14</sup> Ibid §409(3).<sup>15</sup> Ibid §410(2).<sup>16</sup> Ibid §412(3).<sup>17</sup> Ibid §415(2).<sup>18</sup> Ibid §440(1).<sup>19</sup> Ibid §407(1).<sup>20</sup> Ibid §412(1).<sup>21</sup> Ibid §418(1).<sup>22</sup> Ibid. (5)



Тээвэр зуучийн эрх:	Тээвэр зуучийн үүрэг:
<ul style="list-style-type: none"> <li>• Тээвэр зууч нь барааг тээвэрлэх гэрээнд өөрөө гүйцэтгэгчийн хувиар орж болно. Тэрээр энэ эрхээ эдлэх нөхцөлд тээвэрлэгчийн эсвэл дамжуулан тээвэрлэгчийн эрх эдэлж, үүрэг хүлээнэ. Энэ тохиолдолд тэрээр тээвэр зуучийн хөлснөөс гадна <b>ердийн тээврийн хөлсийг шаардах эрхтэй.</b><sup>23</sup></li> <li>• Тээвэр зууч нь гэрээнд бусад илгээгчдийн бараатай хамтатган илгээгчийн зардлаар байгуулсан түүвэр ачааг тээвэрлэх гэрээний дагуу <b>барааг тээвэрлүүлэх эрхтэй.</b><sup>24</sup></li> <li>• Тээвэр зууч нь тээвэр зуучийн гэрээнээс үүдэлтэй шаардах эрхээ барааг илгээх зөвшөөрөл олгосон илгээгчийн болон гуравдагч этгээдийн ачуулсан барааг барьцаалах аргаар хангуулж болно. Илгээгчийн барааг тээвэр зуучлагч нь түүнтэй байгуулсан илгээмжийн, тээвэрлэлтийн болон хадгалалтын бусад гэрээнээс үүдэлтэй шаардлагыг хангуулах зорилгоор <b>барьцаалж болно.</b><sup>25</sup></li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Тээвэр зуучийн үйлчилгээ эрхлэгч нь <b>барааг илгээх үүрэг хүлээнэ.</b><sup>26</sup></li> <li>• <b>Барааг илгээх үүрэг</b> гэдэгт тээвэрлэлтийг зохион байгуулах буюу тээврийн хэрэгсэл ба тээврийн замыг тодорхойлох, гүйцэтгэгчийг сонгох, илгээхэд шаардлагатай тээвэрлэлтийн, хадгалалтын болон тээвэр зуучийн гэрээг байгуулах болон гүйцэтгэгчид мэдээлэл, зааварчилгаа өгөх, илгээгчийн хохирол шаардах эрхийг баталгаажуулах хамаарна. <sup>27</sup> Тээвэрлэлттэй холбоотой даатгал, барааг баглах боох, тэмдэглэгээ хийх болон гаалиар оруулах зэрэг <b>бусад үүрэг хүлээнэ.</b><sup>28</sup></li> </ul>

### 1.1.2. БНФУ

Франц Улсын Иргэний хууль (он бичээрэй)- д тусгагдсан тээвэрлэлтийн гэрээ нь тээвэрлэж буй зүйлээсээ шалтгаалан *хүн тээвэрлэлтийн гэрээ, бараа бүтээгдэхүүн тээвэрлэлтийн гэрээ* гэж ангилагдана. Худалдааны хуулиар зохицуулагдаж буй бараа бүтээгдэхүүн тээвэрлэлтийн гэрээ нь гурван талт харилцааны гэрээнд хамаарах ба барааг тээвэрлэлтэд өгч буй тал, тээвэрлэгч, барааг хүлээн авагч тал оролцдог”<sup>29</sup> гэж тодорхойлсон.

Франц Улсын Иргэний хуульд Монгол Улсын Иргэний хуулийн 380 дугаар зүйлд тусгагдсан Тээвэрлэлтийн гэрээ, 407 дугаар зүйлд тусгагдсан Илгээмжийн гэрээ, 413 дугаар зүйлд тусгагдсан Худалдааны зуучлагч (төлөөлөгч), комиссыг ялгамжтай зохицуулсантай адил тухайн гэрээнүүдийг нэг бүрчлэн ялгаж тодорхойлсон хуулийн тодорхойлолт байхгүй, гагцхүү Иргэний хуулийн 1779 дүгээр зүйлд “тээвэрлэгчийг хөлслөх (түрээслэх)” гэрээний төрөл нь ажил, үйлчилгээ түрээсийн гэрээний нэг тусгай төрөл байхаар зохицуулжээ.

Харин Худалдааны хууль (*Commercial Code*)-д тээвэр зууч (*фр. Des commissionnaires, англ. freight forwarder*)-ийн харилцааг зохицуулсан ба тухайн харилцаанаас үүсэх үр дагавар, үүрэг хариуцлагыг ерөнхий байдлаар зохицуулжээ. Үүнийг

<sup>23</sup> Ibid §458.

<sup>24</sup> Ibid §460(1).

<sup>25</sup> Ibid §464

<sup>26</sup> Ibid §453.

<sup>27</sup> Ibid §454(1).

<sup>28</sup> Ibid §454(2).

<sup>29</sup> Contrat de transport de marchandises - Fiches d'orientation - juillet 2022 | Dalloz, [CAS - Central Authentication Service Login \(univ-paris1.fr\)](https://cas.paris1.fr/).



доорх байдлаар харуулбал:

<p><b>131-1 дүгээр зүйл.</b> Зуучлагчийг (courtier=broker, монгол хэлээр агуулгын хувьд орчуулбал ИХ 415.1 “худалдааны төлөөлөгч эсхүл зуучлагч” болно) дотор нь түүхий эдийн зууч, хэлмэрч зууч, хөлөг онгоцны жолооч, хуурай газрын болон тэнгисийн зууч гэж ангилна.<sup>30</sup></p>
<p><b>132-1 дүгээр зүйл.</b> Тээвэр зууч (<i>фр. Des commissionnaires, англ. freight forwarder</i>)<sup>31</sup> нь өөрийн нэрийн өмнөөс эсхүл өөрийн компанийн нэрийн өмнөөс түүнийг төлөөлөн үүрэг гүйцэтгэдэг этгээд юм.</p>
<p><b>132-3 дугаар зүйл.</b> Хуурай газраар эсхүл далайн буюу усан замаар тээвэрлэлт хийж байгаа тээвэр зууч нь барааны шинж чанар, тоо хэмжээ, шаардлагатай бол үнэ цэний талаарх мэдээллийг тэмдэглэлдээ бичнэ.</p>
<p><b>132-4 дүгээр зүйл.</b> Тээвэр зууч нь хуульд заасан давагдашгүй хүчин зүйл үүссэнээс бусад тохиолдолд тээвэрлэлтийн бичигт (<i>consignment note</i>) заасан хугацаанд барааг хүргэх үүргийг гүйцэтгэнэ.</p>
<p><b>132-5 дугаар зүйл.</b> Тээвэр зууч нь тээвэрлэлтийн бичигт өөрөөр заагаагүй эсхүл давагдашгүй хүчин зүйл нөлөөлсөн тохиолдолд эвдрэл, үр дагаврыг хариуцахгүй.</p>
<p><b>132-7 дугаар зүйл.</b> Гэрээнд өөрөөр заагаагүй бол, худалдагч, дамжуулагчийн дэлгүүр эсхүл агуулахаас тээвэрлэгдэхээр, зөөгдөхөөр гарч байгаа бараа нь түүнийг эзэмшигчийн харьяалалд шилжих үеэс түүнд эрсдэл шилжинэ.</p>
<p><b>132-8 дугаар зүйл.</b> Тээвэрлэлтийн бичиг нь илгээгч, тээвэрлэгч болон хүлээн авагчийн хооронд эсхүл илгээгч, хүлээн авагч, тээвэр зууч, тээвэрлэгчийн (жолооч) хооронд гэрээ үүсгэнэ. Ингэснээр тээвэрлэгч (жолооч) нь илгээгч болон хүлээн авагчийн эсрэг тээвэрлэлтийн төлбөрөө шууд шаардах эрхийг үүсгэнэ. Үүнийг хязгаарласан гэрээний заалт хүчингүй.</p>
<p><b>132-9 дүгээр зүйл.</b> I.- Тээвэрлэлтийн бичигт он, сар, өдөр заагдсан байна. II. - Тээвэрлэлтийн бичигт: 1 тээвэрлэх барааны шинж болон жин эсвэл багтаамж; 2 тээвэрлэлт хийгдэх хугацаа заагдсан байх ёстой. III. - Тээвэрлэлтийн бичиг нь: 1 хэрэв байгаа бол, тээвэрлэлтийн ажлыг явуулж буй тээвэр зуучийн нэр, хаяг; 2 барааг хүлээн авагчийн нэр; 3 тээвэрлэгчийн нэр, хаягийг тодорхойлно. IV. - Тээвэрлэлтийн бичигт : 1 тээврийн хэрэгслийн үнэ; 2 үүргийн гүйцэтгэл хожимдсоноос үүсэх хохирлыг барагдуулах хэмжээг заана. V. - илгээгч эсвэл <i>commissionnaire</i> гарын үсгээ зурна. VI.- тээвэрлэх барааны марк, тоон хэмжээг заана.</p>

<sup>30</sup> Франц Улсын хуульд тусгагдсан энэхүү ойлголт нь Монгол Улсын Иргэний хуулийн 415.1-д “Үйлчлүүлэгчийн нэрийн өмнөөс, түүний зардлаар гэрээ байгуулах буюу бараа, эрх, үйлчилгээг борлуулахад зуучилж байгаа этгээдийг **худалдааны төлөөлөгч гэнэ**” гэсэнтэй нэг адил ойлголт болно.

<sup>31</sup> Франц Улсын хуульд тусгагдсан энэхүү ойлголт нь Монгол Улсын Иргэний хуулийн 415.2-т “Өөрийн нэрийн өмнөөс, гэхдээ бусдын зардлаар барааг борлуулж, эрх хэрэгжүүлэх этгээдийг **комисс гэнэ**” гэсэнтэй нэг адил этгээд болно. Тээвэрлэлтийн гэрээг эд зүйл илгээгчийн нэрийн өмнөөс түүнийг төлөөлж, түүний нэрээр байгуулсан бол зуучлагч (courtier=broker), өөрийн нэрээр ажиллаж, тээвэрлэлтийг чөлөөтэйгээр зохицуулдаг бол тээвэр зууч (agents on commission) болно. [Intermediaires de transport - Transport fluvial et professionnels de la voie d'eau \(developpement-durable.gouv.fr\)](http://Intermediaires.de.transport-Transport.fluvial.et.professionnels.de.la.voie.d'eau.developpement-durable.gouv.fr), (Сүүлд үзсэн: 2023.06.27).



**133-1 дүгээр зүйл.**

Тээвэрлэгч нь тээвэрлэж буй бараа алдагдсан<sup>32</sup> тохиолдолд хариуцлага хүлээх ба ийнхүү алдагдсан нь давагдашгүй хүчин зүйлийн нөлөөллөөс болсон бол хариуцлагаас чөлөөлөгдөнө.

Тээвэрлэгч нь тээвэрлэж буй барааны гэмтэлд хариуцлага хүлээнэ. Гэмтэл нь уг барааны өөрийн гажилтаас эсвэл давагдашгүй хүчин зүйлээс үүдсэн бол хариуцлагаас чөлөөлөгдөнө.

**133-2 дугаар зүйл.**

Хэрэв давагдашгүй хүчин зүйлийн улмаас тээвэрлэлт талуудын тохирсон хугацаанд очоогүй бол тээвэрлэгч энэхүү хоцролтоос үүссэн хохирлыг хариуцахгүй.

**133-5 дугаар зүйл.**

Тээврийн хуулийн (*Code Des Transports*) заалтуудад харшлахгүй тохиолдолд энэхүү бүлэгт заагдсан заалтууд газрын, агаарын, усан тээвэрлэлтэд нэг адил хэрэгжинэ.

**133-6 дугаар зүйл.**

Тээвэрлэгчийн эсрэг тээвэрлэлтийн гэрээн дээр суурилан барааны гэмтэл, алдагдал эсхүл тээвэрлэлтийн хоцролоос үүссэн хохиролтой холбоотой нэхэмжлэлийн шаардлагыг 1 жилийн дотор гаргана. Энэхүү 1 жил нь, хэрэв бараа бүхлээрээ алдагдсан тохиолдолд, хүлээн авагч барааг авах ёстой байсан өдрөөс, бусад бүх тохиолдолд тээвэрлэгч барааг хүлээн авсан өдрөөс тооцогдоно.

Дээрхээс үзвэл, Франц Улсын Иргэний хуульд тээвэрлэлтийн гэрээ, тээвэр зуучийн гэрээ, илгээмжийн гэрээ гэсэн ялгаатай гэрээний төрөл хуульчлагдаагүй, харин ажил, үйлчилгээ түрээсийн гэрээний нэг төрөл нь тээвэрлэгчийг түрээслэх байхаар зохицуулсан нь жолоочид хамаарахаар байна. Үүнээс гадна Худалдааны хуулийн 131, 132 дугаар зүйлд “зуучлагч (худалдааны төлөөлөгч)”, 132 дугаар зүйлд “тээвэр зууч”-ийн ойлголт, хариуцлагыг ерөнхий байдлаар хуульчилсан. Ингэхдээ тухайн этгээд хэний нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулж байгааг шалгуур болгосон байна. Тухайлбал, зуучлагч (courtier=broker) нь гагцхүү үйлчлүүлэгчийг төлөөлөн түүний нэрийн өмнөөс эрх зүйн харилцаанд оролцох, тээвэр зууч (des commissionnaires) нь хувь хүн байх тохиолдолд өөрийн нэрийн өмнөөс, хуулийн этгээд бол компанийг төлөөлөн эрх зүйн харилцаанд оролцохоор ялгаж зохицуулсан.

Хэдийгээр франц хэлээр des commissionnaires буюу орчуулбал “комисс”, англи хэлээр freight forwarder буюу орчуулбал “ачаа илгээгч” гэсэн нэг ойлголт буюу зохицуулалт тусгагдсан ч энэ нь Монгол Улсын Иргэний хуульд тусгагдсан комисс гэх ойлголттой агуулгын хувьд дүйцэхээр байх хэдий ч тэрээр илгээгч, захиалагч хоёрыг холбох, бараа бүтээгдэхүүнийг хүргэх үйл ажиллагааг удирдан, барааг жолоочид дамжуулах чиг үүрэг хэрэгжүүлэх тул “тээвэр зууч” гэж орчуулах нь тохиромжтой гэж үзсэн.

### 1.1.3. ЯПОН УЛС

#### Тээвэрлэлтийн гэрээний ерөнхий ойлголт

Тээвэрлэлтийн гэрээгээр (運送契約) аливаа үйлчилгээг үзүүлэхдээ тээвэрлэгч (運送人) нь газрын тээвэр, далайн тээвэр эсхүл агаарын тээврийн үйлчилгээг үзүүлнэ. Ингэхдээ

<sup>32</sup> Cour de cassation, civile, Chambre commerciale, 5 mai 2015, 14-11.148 14-15.278, Publié au bulletin : дээд шүүхийн худалдааны танхим (commercial chamber), 2015 оны 5 сарын 5: бараа алдагдах гэдэг нь барааг хүлээн авагчид хүргэгдээгүй байдлыг хэлнэ. (absence of presentation of the merchandise) Бараа алдагдах (la perte) : барааг хүлээн авагчид хүргэх боломжгүй болсон нөхцөл байдал. Хэрэв барааны нэг хэсэг л хүргэгдсэн бол хагас алдагдал (la perte partielle/ partial loss), хэрэв тээвэрлэгч барааг хүргэх ямар ч боломжгүй болсон бол бүрэн хэмжээний алдагдал (la perte totale) гэнэ. Retard, pertes, avaries : quelle est la responsabilité du transporteur ? | Weblex (Сүүлд үзсэн: 2023.06.28).



ачаа (物品) болон зорчигч (旅客) тээвэрлэнэ.<sup>33</sup> Далайн тээврийн харилцаа нь (海上運送) “Далайд ачаа тээвэрлэх тухай хууль (海上物品運送法)<sup>34</sup>” гэх тусгай хуулиар зохицуулагдана. Газрын тээвэрт (陸上運送) газрын дээгүүр, газрын доогуурх тээвэр болон боомтын тээвэр багтдаг учир Арилжааны хууль (商法<sup>35</sup>)-д далайн тээвэр болон газрын тээврийн ялгаа зааг тодорхой бус байдаг. Агаарын тээврийн (航空運送) хувьд Арилжааны хуульд тусгайлсан заалт байхгүй, харин 1929 оны “Варшавын конвенц” болон 1955 оны “Варшавын конвенцын нэмэлт өөрчлөлт”, 1999 оны “Монтериалын конвенц”-иор зохицуулагддаг.<sup>36</sup>

Тээвэрлэлтийн гэрээг дотор нь ачаа тээврийн гэрээ, зорчигч тээврийн гэрээ гэж хоёр ангилна. Ачаа тээврийн гэрээ нь тээвэрлэгч ачааг хариуцан тээвэрлэлт хийх гэрээг хэлэх бөгөөд ачаа тээврийн гэрээний оролцогчид нь нэг талаас ачаа илгээгч (荷送人) нөгөө талаас тээвэрлэгч байна. Ачааг хүлээн авагч нь гэрээний оролцогч тал болохгүй.<sup>37</sup> Энэхүү харьцуулсан судалгаанд ачаа тээврийн гэрээний ойлголт, онцлогийг судалсан болно.

### Тээвэр зуучийн гэрээний ерөнхий ойлголт

Тээвэр зуучийн гэрээгээр (運送取扱契約) **зуучлагч (運送取扱人)** нь үйлчилгээ үзүүлэхдээ өөрийн нэрээр ачаа тээврийн зуучлалын (取次ぎ<sup>38</sup>) үйлчилгээ үзүүлнэ.<sup>39</sup> Зуучлагч нь тээвэрлэлтийн гэрээний зуучлалыг хийдэг этгээд буюу өөрөөр хэлбэл бараа илгээх гэж байгаа үйлчлүүлэгчийн төлөө өөрийн нэрээр тээвэрлэгчтэй тээвэрлэлтийн гэрээ байгуулж байгаа этгээдийг хэлнэ.

### Худалдааны зуучийн ерөнхий ойлголт

Худалдааны зуучлагч (仲立人) гэж өөр этгээдүүдийн хоорондын аж ахуйн үйл ажиллагааны (商行為) зуучлал (媒介<sup>40</sup>) явуулж байгаа этгээдийг хэлнэ.<sup>41</sup> Мөн уг гэрээ нь

<sup>33</sup> 商法 (1899年) 569条「この法律において、次の各号に掲げる用語の意義は、当該各号に定めるところによる」。569条1項1号「運送人 陸上運送、海上運送又は航空運送の引受けをすることを業とする者をいう」。569条1項2号「陸上運送 陸上における物品又は旅客の運送をいう」。569条1項3号「海上運送 第六百八十四条に規定する船舶（第七百四十七条に規定する非航海船を含む。）による物品又は旅客の運送をいう」。569条1項4号「航空運送 航空法（昭和二十七年法律第二百三十一号）第二条第一項に規定する航空機による物品又は旅客の運送をいう」。

<sup>34</sup> 昭和三十二年法律第七十二号, <https://elaws.e-gov.go.jp/document?lawid=332AC0000000172>.

<sup>35</sup> 明治三十二年法律第四十八号 [https://elaws.e-gov.go.jp/document?lawid=132AC0000000048\\_20200401\\_429AC0000000045](https://elaws.e-gov.go.jp/document?lawid=132AC0000000048_20200401_429AC0000000045).

<sup>36</sup> 藤田勝利・工藤聡—『Next教科書シリーズ（現代商取引法）』（弘文堂・2011年）166-167頁。

<sup>37</sup> 同上、167頁。

<sup>38</sup> Өөрийн нэрээр бусад хүний төлөө хэлцэл хийх.

<sup>39</sup> 商法（1899年）559条「この章において「運送取扱人」とは、自己の名をもって物品運送の取次ぎをすることを業とする者をいう」。

<sup>40</sup> Өөрөө гэрээний нэг тал болохгүйгээр өөр этгээдүүд хооронд хэлцэл хийхэд зуучлах.

<sup>41</sup> 商法（1899年）543条「この章において「仲立人」とは、他人間の商行為の媒介をすることを業とする者をいう」。



худалдааны зуучлагч болон итгэмжлэгч (委託者) нарын хооронд байгуулагдана.<sup>42</sup> **Худалдааны зуучлал (仲立ち)** нь өөр этгээдүүдийн хооронд хэлцэл (法律行為) хийхэд зуучлахыг хэлнэ. Худалдааны зуучлалын үйл ажиллагаа явуулагч нь (仲立ち営業者) зуучилж буй хэлцлийнхээ (取引) оролцогч (当事者) болохгүй. Төлбөр (報酬) нь зуучлалын хөлс (媒介手数料) болно.<sup>43</sup>

Худалдааны зуучлагч нь аж ахуй эрхлэгч хооронд аж ахуйн үйл ажиллагааны зуучлал явуулдаг худалдааны зуучлагч (商事仲立人), хувь хүмүүс хооронд орон сууц, барилгын худалдааг зуучлах үйл ажиллагаа явуулдаг худалдааны зуучлагч (民事仲立人) гэж ангилна. Худалдааны зуучлагч нь гэрээгээ хүчин төгөлдөр (有効) байгуулахгүй аваас төлбөр болох зуучлалын хөлсөө шаардах эрхээ алдана.<sup>44</sup>

### Комиссын ерөнхий ойлголт

**Комисс (問屋)** нь өөрийн нэрээр үйлчлүүлэгчийн (委託者) хөрөнгөөр бараа худалдан авах, худалдаалах үйл ажиллагаа эрхэлдэг этгээдийг хэлнэ.<sup>45</sup> Комисс нь үйлчлүүлэгчийн төлөөлөгчийн (代理人) хувиар биш өөрөө шууд гэрээний оролцогч болон гэрээ хийн явдаг учир эрх зүйн үр дагавар (法律効果) бүгд комисст хамаарна. Улмаар үйлчлүүлэгч нь хэлцлийн нөгөө талтай шууд эрх зүйн харилцаа үүсгэхгүй.<sup>46</sup>

### Тээвэрлэгчийн гэрээгээр хүлээх эрх

Тээвэрлэгч нь ачаа илгээгчээс дагалдах бичиг (運送状)-ийг хийх, гардуулж өгөхийг шаардах эрхтэй бөгөөд дагалдах бичиг нь тээвэрлэлтийн гэрээний агуулгыг нотлох, нотлох баримтын үүднээс үр дүнтэй байдаг<sup>47</sup> буюу тээвэрлэгч, илгээгч хоёрын хоорондын гэрээний нотлох баримтын үүргийг гүйцэтгэх нотлох үнэт цаас (証拠証券) юм.<sup>48</sup> Арилжааны хуулийн 571 дүгээр зүйлд заасны дагуу дагалдах бичигт илгээгч нь дараах мэдээллийг тусгаж, тээвэрлэгчид өгнө:

- Барааны төрөл;
- Барааны багтаамж, хүнд, тоо, барааны код;
- Баглаж, боосон төрөл /байдал/;
- Илгээгч болон хүлээн авагчийн нэр;
- Илгээсэн буй газар болон хүлээн авах газар.

Тээвэрлэгч нь бүрэн бус дагалдах бичгийн дагуу ачаа бараатай харьцаж, түүний үр дүнд ачаа гэмтэж (毀損), үрэгдсэн (滅失) бол дагалдах бичгийг үндэслэн хохирлыг барагдуулах хариуцлагыг хүлээхгүйгээ маргаж (主張する) болохоос гадна дагалдах бичигт

<sup>42</sup> 北居 功・高田晴仁『民法とつながる商法総則・商行為法』（商事法務・2013年）274頁。

<sup>43</sup> 近藤光男『現代商法入門（第8版）』（有斐閣アルマ・2009年）213頁。

<sup>44</sup> 同上。

<sup>45</sup> 商法（1899年）551条「この章において「問屋」とは、自己の名をもって他人のために物品の販売又は買入れをすることを業とする者をいう。」

<sup>46</sup> 前掲注（44）289–290頁。

<sup>47</sup> 前掲注（43）224頁。

<sup>48</sup> 前掲注（37）168頁。



үндэслэн өөрт учирсан хохирлын нөхөн төлбөрийг ачаа илгээгчээс шаардаж болох<sup>49</sup> буюу ачаа илгээгчийн гэм буруугийн санаатай (故意) болон болгоомжгүй (過失) байдлаас дагалдах бичиг худал (不実), эсхүл үнэн бус (不正確) байдлаар бичигдэж түүнээс тээвэрлэгчид хохирол учирсан тохиолдолд ачаа илгээгчид уг хохирлыг нөхөн төлөх хариуцлага (損害賠償責任) үүснэ.<sup>50</sup> Дагалдах бичигт хууль эрх зүйн асуудлын тодорхойлолт (法定事項の記載<sup>51</sup>) болон илгээгчийн гарын үсэг хэрэгтэй.

Бүх ачаа эсхүл ачааны зарим хэсэг үрэгдсэн ч, тэр нь барааны чанарын байдлаас шалтгаалсан эсвэл чанарын доголдлоос (瑕疵) үүссэн тохиолдолд мөн ачаа илгээгчийн гэм буруугийн болгоомжгүй байдлаас үүдсэн тохиолдолд тээвэрлэгч тээврийн хөлсийг бүхэлд нь шаардах эрхтэй. Түүнээс бусад тохиолдолд тээвэрлэгч өөрийн гэм буруугаас эсвэл аль нэг талд нь хамааруулах боломжгүй нөхцөл байдал үүссэн тохиолдолд тээврийн хөлсийг шаардах эрхгүй.<sup>52</sup>

Бүх ачаа эсхүл ачааны зарим хэсэг давагдашгүй хүчин зүйлийн (不可抗力) улмаас үрэгдсэн тохиолдолд тээвэрлэгч тээврийн хөлсөө шаардах боломжгүй бөгөөд хэрэв тээвэрлэгч аль хэдийн тээврийн хөлсийг бүхэлд нь эсхүл зарим хэсгийг авчихсан бол түүнийг буцаах боломжгүй. Тээврийн хөлс болон бусад зардлыг төлөх үүрэгтэй этгээд нь ачаа илгээгч хэдий ч ачаа хүлээн авагч ачааг авсан тохиолдолд тээвэрлэгч тээврийн хөлс болон бусад зардлаа ачаа хүлээн авагчаас ч мөн шаардах эрхтэй болно. Тээвэрлэгчийн тээврийн хөлс болон бусад зардлыг шаардах уг эрх нь 1 жилийн хөөн хэлэлцэх хугацаатай<sup>53</sup> ба тээвэрлэгч тээврийн хөлс болон бусад урьдчилсан төлбөрийг (立替払い) төлөх хүртэл ачааг өөртөө байлгах (留置権<sup>54</sup>) эрхтэй.<sup>55</sup>

Хэрэв ачааг хүлээн авах этгээд тодорхой бус байх, ачааны тоо хэмжээ болон бараа бүтээгдэхүүний зөрүү, хүлээн авагчийн шаардлагыг хангасан эсэх тухай маргаан байгаа тохиолдолд илгээгч нь барааг хадгалж (供託する) болохоос гадна ачааг хүлээн авах этгээд тодорхой бус байгаа үед тээвэрлэгч нь ачааг дуудлага худалдаанд (競売) оролцуулж болно.

Ачааг гардуулж өгөх тал дээр маргаан гарсан бол тээвэрлэгч нь ачааг хүлээн авагчид тохиромжтой (相当) хугацаа өгч хэзээ хүлээн авахыг нь мэдэгдэж уг хугацаа өнгөрвөл ачаа илгээгчид ачааг захиран зарцуулах (処分) зааварчилгааг мэдэгдэн түүний дараагаар ачааг дуудлага худалдаанд оруулна.<sup>56</sup>

### Тээвэрлэгчийн гэрээгээр хүлээх үүрэг

Ачаа бүхэлдээ үрэгдсэн<sup>57</sup> тохиолдолд ачааг хүлээлгэж өгөх ёстой байсан өдрийн тухайн газрын ханшаар (価格), ачааны зарим хэсэг үрэгдсэн эсхүл гэмтсэн тохиолдолд

<sup>49</sup> 前掲注 (43)。

<sup>50</sup> 前掲注 (37) 168頁。

<sup>51</sup> Eng: Description of Legal matters.

<sup>52</sup> 前掲注 (43) 224-225 頁。

<sup>53</sup> 前掲注 (37) 168 頁。

<sup>54</sup> Саатуулан барих эрх.

<sup>55</sup> 前掲注 (43) 225 頁。

<sup>56</sup> 同上。

<sup>57</sup> “Үрэгдсэн” гэдэгт биет байдлын үрэгдлээс гадна хулгай, алдах, зөвшөөрөлгүй этгээдэд хүлээлгэн



хугацаа хожимдол байхгүй бол хүлээлгэж өгөх ёстой байсан өдрийн тухайн газрын ханшаар хохирлын нөхөн төлбөрийн хэмжээг тогтооно. Гэхдээ дээрх тохиолдлуудын аль алинд нь тээврийн хөлс болон бусад зардлыг хасаж тооцно.

Хэрэв тээвэрлэгч санаатай (悪意) болон ноцтой хайхрамжгүй байдал (重過失) гаргасан бол энэ нь хамаарахгүй. Тээвэрлэгчид санаатай болон ноцтой хайхрамжгүй байдал байсныг нотлох үүрэг ачаа илгээгчид ногдоно.<sup>58</sup> Ачааг хугацаанд хүргээгүйн улмаас хохирол учирсан тохиолдолд дээрхүүд нь хамаарахгүй ба тээвэрлэгч нь иргэний хуулийн ерөнхий зарчимд (一般原則) үндэслэн гарсан бүх (一切) хохирлыг нөхөн төлөх ёстой.<sup>59</sup>

Ачааг хүлээн авагч нь ачааг хүлээн авч, тээврийн хөлс болон бусад зардлыг төлөх үедээ эхлээд ачааг шалгаж, гэмтэл эсхүл зарим хэсэг нь үрэгдсэн байгааг олсон үедээ хариуцлагыг нөхөн тооцохгүй (留保) тээвэрлэгчийн эсрэг хохирлын нөхөн төлбөрийг шаардах эрхээ алдана. Шууд олох боломжгүй гэмтэл эсхүл зарим хэсгийн үрэгдэл байсан тохиолдолд хүлээн авагч нь ачааг гардаж авснаас хойш 2 долоо хоногийн дотор хохирлоо шаардана. Хэрэв тээвэрлэгчид санаатай гэм буруу (悪意) байсан тохиолдолд хөөн хэлэлцэх хугацаа тооцохгүй. Тээвэрлэгчийн хариуцлага нь хүлээн авагч ачааг хүлээж авсан өдрөөс хойш 1 жил, эсхүл ачаа бүхэлдээ үрэгдсэн тохиолдолд ачааг гардаж авах ёстой байсан өдрөөс хойш 1 жил өнгөрсний дараа хөөн хэлэлцэх хугацаа дуусна. Гэхдээ тээвэрлэгч нь санаатайгаар ачааг гэмтээж, үрэгдүүлсэн тохиолдолд хөөн хэлэлцэх хугацаа тооцохгүй.<sup>60</sup>

Тээвэрлэгч өөрийн эсвэл ажил олгогчийн (使用人) гэм буруугийн санаатай эсхүл болгоомжгүй байдлаас ачаанд хохирол учруулсан бол үүргийн зөрчлөөс үүдэх хариуцлага (債務不履行責任)-ын дээр ачааны өмчлөх эрхийг зөрчсөн гэж гэм хорын нөхцөл ч хангагдах боломжтой. Энэ тохиолдолд Арилжааны тухай хуулийн 577-р зүйлээс хойших заалтуудад үндэслэн хохирлын нөхөн төлбөрийг шаардах эрх үүсэх үү эсвэл иргэний хуулийн гэм хорын хариуцлагад үндэслэх хохирлын нөхөн төлбөрийг шаардах эрх үүсэх үү гэх нэг хохиролд хоёр шаардах эрх үүсэх асуудал асуудал тулгарах бөгөөд онолын тайлбар (通説) болон өмнө нь гарсан шүүхийн шийдвэрүүд (判例) маргаантай байр сууринд байгаа.<sup>61</sup>

### Зуучлагчийн гэрээгээр хүлээх эрх

Зуучлал хийх явцад гаргасан зардлаа үйлчлүүлэгчээс (委託者) шаардаж болно. Зуучлагч нь төлбөр, тээврийн хөлс, үйлчлүүлэгчийн өмнөөс урьдчилсан төлсөн мөнгийг төлөх хүртэл ачааг өөртөө хадгалах эрхтэй. Зуучлагч нь тусгай заалт (特約) байхгүй тохиолдолд өөрөө тээвэрлэгчийн хувиар ачааг тээвэрлэж болно.<sup>62</sup>

---

өгсөн зэрэг бодитоор хүлээлгэн өгөх боломжгүй болсон нөхцөлүүд хамаарна. 滅失」には、物理的滅失のほか、盗難・紛失・無権利者への譲渡などにより事実上引き渡すことができなくなった場合も含まれる。最判昭和35年3月17日民集14巻3号451頁〔百選94事件〕参照。

<sup>58</sup> 前掲注(37) 171頁。

<sup>59</sup> 同上、172頁。

<sup>60</sup> 同上、173頁。

<sup>61</sup> 同上。

<sup>62</sup> 前掲注(43) 229頁。



## Зуучлагчийн гэрээгээр хүлээх үүрэг (Тээвэр)

Зуучлагч нь ачааг хүлээж авснаас хүлээн авагчид ачааг хүлээлгэн өгөх хүртэл ачааг үрэгдүүлэх, гэмтээх, эсхүл үрэгдүүлсэн, гэмтээх шалтгаан нөхцөлийг үүсгэсэн, эсхүл бараа саатсан бол үүнээс учирсан хохирлыг барагдуулах хариуцлагыг хүлээнэ.

Харин зуучлагч нь ачааг хүлээн авах, хадгалах эсхүл хүлээлгэн өгөх, тээвэрлэгчийг сонгох болон бусад тээвэр зуучлалын ажлыг орхигдуулаагүй нь нотлогдсон тохиолдолд энэ зүйл хамаарахгүй.<sup>63</sup>

### 1.2. АВТО ЗАМ, ТӨМӨР ЗАМ, АГААРЫН ТЭЭВРИЙН ЯЛГААТАЙ ОНЦЛОГ ЗОХИЦУУЛАЛТ

#### 1.2.1. ХБНГУ

ХБНГУ-д *авто зам, төмөр зам, агаарын тээвэр, усан тээвэр* гэх нийт 4 төрлийн тээвэр байдаг ба тус тусдаа бие даасан хууль, дүрэм журмаар зохицуулагддаг. Усан замын тээврээс бусад төрлийн тээврийг доорх байдлаар дэлгэрүүлж судлав:

Авто зам	<p>Авто замын тээврийн харилцааг олон улсын конвенц болох “Олон улс хоорондын авто замаар ачаа тээвэрлэх гэрээний тухай конвенц” (1956, Convention on the Contract for the International Carriage of Goods by Road) ба дотоодын хууль тогтоомж болох Зам тээврийн тухай хуулиар (1998, Güterkraftverkehrsgesetz) тус тус зохицуулдаг.</p> <p>ХБНГУ нь “Олон улс хоорондын авто замаар ачаа тээвэрлэх гэрээний тухай конвенц”-д 1961 онд нэгдэн орсон ба олон улс хоорондын авто замаар ачаа тээвэрлэх харилцааг тус Конвенцын дагуу зохицуулдаг. Конвенцын 4 дүгээр бүлэгт тээвэрлэгчийн хариуцлагыг заасан ба тус бүлгийн 17 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт доорх агуулга бүхий зохицуулалт тусгагджээ.</p> <p><i>18 дугаар зүйлийн 2, 5 дахь хэсгийн заалтуудын дагуу дараах нөхцөл байдлуудаас нэг буюу хэд хэдэн бие биеэсээ харилцан хамаарал бүхий нөхцөл байдал үүссэний улмаас ачаанд гэмтэл, хохирол учирвал түүнийг тээвэрлэгч хариуцахгүй. Эдгээр нь:</i></p> <p><i>е) ачааны баглаа боодлын тэмдэглэгээ, дугаар хангалттай бус байх</i></p> <p><i>18 дугаар зүйлийн 2 дох хэсэг:</i></p> <p><i>Хэрэв 17 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан нэг буюу хэд хэдэн онцгой эрсдэл бүхий нөхцөл байдлын үр дүнд ачаа үрэгдэж гэмтсэнийг тээвэрлэгч нотолж чадвал энэ нь үүнээс шалтгаалсныг хүлээн зөвшөөрөх үндэслэл болох юм. Гэхдээ нэхэмжлэгч нь ачаа үрэгдэж гэмтсэн нь дурдсан нөхцөл байдлаас бүхэлдээ буюу хэсэгчлэн хамааралгүйг нотлох эрхтэй.</i></p>
----------	--

<sup>63</sup> 商法 (1899年) 560条 「運送取扱人は、運送品の受取から荷受人への引渡しまでの間にその運送品が滅失し若しくは損傷し、若しくはその滅失若しくは損傷の原因が生じ、又は運送品が延着したときは、これによって生じた損害を賠償する責任を負う。ただし、運送取扱人がその運送品の受取、保管及び引渡し、運送人の選択その他の運送の取次ぎについて注意を怠らなかつたことを証明したときは、この限りでない」。



	<p>Дээрх зохицуулалтаас харвал ачааны баглаа боодлын тэмдэглэгээ, дугаар хангалттай бус байснаас болоод ачаанд гэмтэл, хохирол учирвал тээвэрлэгч нь тухайн нөхцөл байдал өөрөөс нь үл шалтгаалж бий болсон гэдгийг нотолж уг хохирлыг хариуцахгүй байхаар заажээ.</p>
<p><b>Төмөр зам</b></p>	<p>Төмөр замын тээврийн харилцааг олон улсын конвенц болох Олон улсын төмөр замын тээврийн тухай конвенц (1999, The Convention concerning International Carriage by Rail), мөн уг конвенцын доторх Олон улсын төмөр замаар ачаа тээвэрлэх гэрээний нэгдсэн дүрэм (Uniform Rules Concerning the Contract of International Carriage of Goods by Rail) ба дотоодын хууль тогтоомж болох Төмөр замын тухай хуулиар (2016, Eisenbahnregulierungsgesetz) тус тус зохицуулдаг.</p> <p>Олон улсын төмөр замаар ачаа тээвэрлэх гэрээний нэгдсэн дүрмийн 6 дугаар зүйлд тээвэрлэлтийн гэрээг зохицуулсан байдаг. Тээвэрлэлтийн гэрээ нь нэгдсэн загварт нийцсэн дагалдах бичиг үйлдсэнээр баталгааждаг<sup>64</sup> ба уг дагалдах бичигт ачаа илгээгч болон тээвэрлэгч нар гарын үсэг зурдаг.<sup>65</sup> <i>Тус дагалдах бичигт ачааг тодорхойлоход шаардлагатай тусгай тэмдэглэгээ, дугаар болон багцын (баглаа боодол) тоог тусгах ёстой.</i><sup>66</sup> 8 дугаар зүйлд дагалдах бичигт тусгагдсан мэдээлэлд хүлээх хариуцлагын талаар тусгасан ба <i>дагалдах бичигт илгээгчийн оруулсан мэдээлэл буруу, дутуу эсвэл зааварт зааснаас өөр газарт бичигдсэн</i><sup>67</sup> эсвэл илгээгч нь RID-ээс тогтоосон бичилтийг хийгээгүйн<sup>68</sup> улмаас тээвэрлэгчид хохирол учирвал түүнд учирсан <i>бүхий л зардал, алдагдал эсвэл хохирлыг илгээгч хариуцахаар заажээ.</i> Харин дагалдах бичигт “ачаа тээвэрлэлт нь ямар ч тайлбаргүйгээр энэхүү Конвенцийн заалтуудаар тогтоогдсон журмын дагуу явагдаж байгаа гэсэн заалт”<sup>69</sup>-ын агуулга тусгагдаагүй тохиолдолд үүний улмаас учирсан бүхий л зардал, алдагдал эсвэл хохирлыг тээвэрлэгч хариуцна.<sup>70</sup></p> <p>15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар <i>барааг хүргэхээс өмнө гаалийн болон захиргааны байгууллагаас шаардсан албан ажиллагааг асуудалгүй явуулахын тулд илгээгч нь шаардлагатай бичиг баримтыг дагалдах бичигт хавсаргах эсхүл тээвэрлэгчид өгч түүнийг шаардлагатай бүх мэдээллээр хангах ёстой.</i><sup>71</sup> Харин тээвэрлэгч нь эдгээр бичиг баримт болон мэдээллийн үнэн зөв, хангалттай байгаа эсэхийг шалгах үүрэг хүлээхгүй ба <i>тус бичиг баримт, мэдээлэл байхгүй, хангалтгүй эсвэл зөрчилтэй байсны улмаас тээвэрлэгчид учирсан аливаа алдагдал эсвэл хохирлыг илгээгч тээвэрлэгчийн өмнө хариуцна.</i><sup>72</sup></p>
<p><b>Агаарын тээвэр</b></p>	<p>Агаарын тээврийн харилцааг олон улсын конвенц болох Олон улсын иргэний нисэхийн тухай Чикагогийн конвенц (1944, Convention on International Civil Aviation), Монреалийн конвенц (1999, The Montreal Convention), болон дотоодын хууль тогтоомж болох Нисэхийн тухай хуулиар (1922, Luftverkehrsgesetz) тус тус зохицуулдаг.</p>

<sup>64</sup> CIM, §2 Article 6,

<sup>65</sup> *Ibid* §3.

<sup>66</sup> *Ibid* §1 i) Article 7.

<sup>67</sup> *Ibid* §1 a) Article 8.

<sup>68</sup> *Ibid* §1, b).

<sup>69</sup> *Ibid* §1 p) Article 6.

<sup>70</sup> *Ibid*. §3 Article 8

<sup>71</sup> *Ibid* §1 Article 15.

<sup>72</sup> *Ibid*. §2



	<p>Монреалийн конвенцийн 16 дугаар зүйлд гааль, цагдаа болон бусад төрийн байгууллагын албан ёсны шаардлагын талаар тусгажээ. <i>Илгээгч нь ачааг хүргэхээс өмнө гааль, цагдаа болон бусад төрийн байгууллагын албан ёсны шаардлагыг хангахад шаардагдах мэдээлэл, баримт бичгийг бүрдүүлж өгөх ёстой.</i> Тээвэрлэгч, түүний туслах эсвэл төлөөлөгчийн буруугаас болоогүй л бол тэрхүү мэдээлэл, баримт бичиг байхгүй, дутуу эсвэл зөрчилтэй байгаагийн улмаас учирсан хохирлыг ачаа илгээгч хариуцна.<sup>73</sup> <i>Мөн тээвэрлэгч нь дээрх мэдээлэл, баримт бичгийн үнэн зөв, хангалттай байгаа эсэхийг шалгах үүрэг хүлээхгүй.</i><sup>74</sup></p>
--	---

### 1.2.2. БНФУ

Франц Улсын Худалдааны хуулийн 133-5 дугаар зүйлд “Тээврийн хуулийн (Code Des Transports) заалтуудад харшлахгүй тохиолдолд энэхүү бүлэгт заагдсан заалтууд газрын, агаарын, усан тээвэрлэлтэд нэгэн адил хэрэгжинэ” гэж зааснаас үзвэл тээвэрлэлтийг гүйцэтгэх арга зам буюу авто замаар эсхүл агаарын замаар эсхүл төмөр замаар эсхүл усан замаар тээвэрлэхээс үл хамааран Худалдааны хуулийг баримтлах үндэслэлтэй.

Иймд тээвэрлэлтийн бичигтэй холбогдох зохицуулалт, бараа давагдашгүй хүчин зүйлийн улмаас устах, гэмтэх, алдагдах тохиолдолд хүлээлгэх хариуцлагын ерөнхий заалтыг баримтлах үндэслэлтэй байна.

### 1.2.3. ЯПОН УЛС

Япон Улсын хууль тогтоомжид авто зам, төмөр зам болон агаарын тээврийн төрлөөс хамаарч, гэрээгээр хүлээх эрх, үүрэг, хариуцлагыг ялгаатай байдлаар зохицуулаагүй.

## 1.3. ГЭРЭЭНИЙ ҮҮРЭГТЭЙ ХОЛБООТОЙГООР АЧАА, БАРААНД УЧИРСАН ХОХИРОЛ, ГЭМ ХОРЫГ ШААРДАХ, ТҮҮНД ХАМААРАХ ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА

### 1.3.1 ХБНГУ

ХБНГУ нь Handelsgesetzbuch буюу Арилжааны тухай хуулиар гэрээний үүргийн дагуу болон гэрээний бус үүргийн дагуу шаардах эрх, хариуцлагын талаар зохицуулсан байна. Тус хуульд илгээгч болон тээвэрлэгч нь ямар тохиолдолд хохирол, учирсан гэм хорыг нөхөн төлөх хариуцлагыг хүлээх болон шаардах эрхийг хэрэгжүүлэх талаар зохицуулсан. Үүнд:

#### Тээвэрлэлтийн гэрээний хувьд:

*Гэрээний үүргийн дагуу* оролцогч аливаа этгээд нь дараах тохиолдолд хохирол болон учирсан гэм хорийг шаардах эрхээ хэрэгжүүлэх болон хариуцлагыг хүлээнэ. *Илгээгч* нь дараах тохиолдолд гэм буруугүй байсан ч тээвэрлэгчид учирсан хохирол, гарсан

<sup>73</sup> The Monreal Convention (1999), 1 Article 16.

<sup>74</sup> *Ibid* 2.



зардлыг хариуцна<sup>75</sup>:

- 1.2.3.1. Сав баглаа боодол, тэмдэглэгээ шаардлага хангаагүй;
- 1.2.3.2. Дагалдах бичигт тусгасан мэдээлэл буруу, дутуу;
- 1.2.3.3. Аюултай барааны талаар мэдээлээгүй орхигдуулсан;
- 1.2.3.4. Энэ хуулийн 413.1-д заасан баримт бичиг (дагалдах баримт, бичиг), мэдээлэл байхгүй, дутуу, буруу байх.

- Тээвэрлэгчийн үйл хөдлөл хохирол үүсэх, зардал гарахад нөлөөлсөн бол дээрх хохирол, зардал нэхэмжлэх эрхийн хэмжээ түүний үйл хөдлөл нийт хохирол, зардалд хэрхэн нөлөөлснөөс шууд хамаарна<sup>76</sup>. Илгээгч нь хэрэглэгч бол энэ зүйлийн 1, 2 дах мөрд заасан хохирол, зардлыг тээвэрлэгч гагцхүү гэм буруутай нөхцөлд хариуцан арилгана.<sup>77</sup>
- **Тээвэрлэгч** барааг хүлээн авснаас эхлээд тээвэрлэж, хүлээлгэн өгөх хүртэл барааг алдсан, гэмтээсэнтэй холбоотой хохирол эсхүл нийлүүлэх хугацааг хэтрүүлсэнтэй холбоотой хохирлыг хариуцан арилгана.<sup>78</sup> Хохирол учрахад *илгээгчийн* эсхүл *хүлээн авагчийн* үйл хөдлөл эсхүл *барааны тодорхой төрлийн доголдол* нөлөөлсөн бол хохирлын нөхөн төлөх үүрэг, хохирлын хэмжээ нь эдгээр нөхцөл бий болоход нөлөөлсөн хувь нэмрээс хамаарна.<sup>79</sup>
- Тээвэрлэгч үүргээ гүйцэтгэх явцад ажилтнуудаа оролцуулсан бол тэдгээрийн үйлдэл, эс үйлдэхүйг өөрийн мэт тооцуулж хариуцлага хүлээнэ. Тээвэрлэлтийг гүйцэтгэх явцад оролцож буй этгээдийн үйлдэл, эс үйлдэхүйн өмнөөс мөн хариуцлага хүлээнэ.<sup>80</sup>
- Тээвэрлэгч ачааг бүхэлдээ эсхүл хэсгийг нь алдсаны улмаас хохирлыг нөхөн төлөх ёстой бол тээвэрлэлтэд шилжүүлсэн газрын тухайн үеийн үнэлгээг нөхөн төлнө.<sup>81</sup> Ачаа бараа гэмтсэн бол тээвэрлэлтэд шилжүүлсэн газар, цаг хугацаан дор гэмтэлгүй барааны үнэ болон хүлээлгэн өгөх газар дах тухайн үеийн гэмтэлтэй барааны үнийн зөрүүг төлнө. Хохирлыг багасгах, арилгахтай холбоотой зардал нь энэ заалтын 1-д заасан зөрүүтэй тэнцүү гэсэн таамаг үйлчилнэ.<sup>82</sup> Ачаа алдагдсан эсвэл гэмтсэн бол тээвэрлэгч энэ хуулийн §429-т заасан нөхөн төлбөрөөс гадна хохирлын хэмжээг тодорхойлоход гарсан зардлыг хариуцна.<sup>83</sup>

### **Хариуцлагаас чөлөөлөгдөх үндэслэл**

**Тээвэрлэгч** нь маш анхаарал болгоомжтой хандаад ч хохирол учрахаас сэргийлж үл чадах, үр дагаврыг нь арилгаж үл чадах байсан нөхцөл байдлаас болж бараа гээгдсэн, гэмтсэн эсхүл нийлүүлэх хугацааг хэтрүүлсэн бол тээвэрлэгч хариуцлагаас чөлөөлөгдөнө.<sup>84</sup> Тээвэрлэгч нь ачаа алдагдсан, гэмтсэн, нийлүүлэх хугацааг хэтрүүлсэн явдал нь дараах эрсдэлтэй холбоотой бол<sup>85</sup> хариуцлага хүлээхгүй:

1. Гэрээгээр тохирсон эсхүл хэрэглэж хэвшсэн нээлттэй, төлөвлөгөөнд багтаагүй тээврийн хэрэгслээр тэвшинд ачиж, буулгасан;

<sup>75</sup> Handelsgesetzbuch (1897), §414-(1)-1, [Commercial Code \(Handelsgesetzbuch – HGB\) \(gesetze-im-internet.de\)](http://www.gesetze-im-internet.de), (Сүүлд үзсэн: 2023.06.27).

<sup>76</sup> *Ibid* §414-(2).

<sup>77</sup> *Ibid* §414-(3).

<sup>78</sup> *Ibid* §425-(1).

<sup>79</sup> *Ibid* §425-(2).

<sup>80</sup> *Ibid* §428.

<sup>81</sup> *Ibid* §429 (1).

<sup>82</sup> *Ibid* §429(2).

<sup>83</sup> *Ibid* §430.

<sup>84</sup> *Ibid* §426.

<sup>85</sup> *Ibid* §427.



2. Илгээгч савлагаа боодлыг хангалтгүй хийсэн;
3. Илгээгч эсвэл хүлээн авагч барааг янзалж, ачиж, буулгасан;
4. Бараа бүтээгдэхүүний байгалиас заяасан шинж чанар нь эвдэрч гэмтэх, зэврэх, дотроосоо муудах, хатах, хугацаа нь дуусах, ердийн байдлаар элэгдэх;
5. Илгээгч ачааны тухай тэмдэглэгээг хангалтгүй хийсэн;
6. Амьд амьтдын тээвэрлэлт.

Гэрээний бус үүргийн шаардах эрхэд энэхүү дэд хэсэгт болон тээвэрлэлтийн гэрээнд заасан хариуцлагаас чөлөөлөх, хязгаарлах тухай зохицуулалт нь илгээгчийн эсхүл хүлээн авагчийн зүгээс тээвэрлэгчийн эсрэг ачаа алдагдсан, гэмтсэн, хугацаа хэтрүүлснээс үүдэх гэрээний бус үүргийн шаардах эрхийн хувьд ч нэгэн адил үйлчилнэ.<sup>86</sup>

Тээвэрлэгч нь мөн гуравдагч этгээдийн ачаа алдагдсан, гэмтсэн нь гэрээтэй холбоотой бус үүргийн шаардах эрхийн эсрэг энэ зүйлийн 1 дэх мөрд заасан эсэргүүцлийг гаргаж болно. Гэхдээ эсэргүүцлийг дараах тохиолдолд гаргах боломжгүй<sup>87</sup>:

1. Эсэргүүцэл нь энэ хуулийн §449.1-ийн 1 дэх өгүүлбэрт дурдсан хуулийн зохицуулалтыг илгээгчид ашиггүй байхаар өөрчилсөн гэрээний тохиролцоонд суурилсан,
2. Гуравдагч этгээд нь ачаа тээвэрлэх зөвшөөрөл олгоогүй бөгөөд тээвэрлэгч илгээгчийг ачаа тээвэрлэх эрхгүй болохыг мэдэж байсан эсхүл хайхрамжгүйн улмаас мэдээгүй,
3. Ачааг тээвэрлүүлэхээр гуравдагч этгээдэд шилжүүлэхээс өмнө алдагдсан.

#### Илгээмжийн/тээвэр зуучийн гэрээний хувьд:

Илгээгч нь гэм буруутай эсэхээс үл хамааран илгээмжийн үйлчилгээ эрхлэгчид дараах хохирлыг нөхөн төлнө<sup>88</sup>:

1. Сав баглаа, одер тэмдэглэгээ хангалтгүй,
2. Аюултай бараа илгээж буй тухай мэдэгдээгүй эсвэл
3. Холбогдох баримт бичиг дутуу эсвэл барааг тээвэрлэх явцад авах арга хэмжээний талаар тусгаагүй.

Мөн илгээгч нь хэрэглэгч бол гагцхүү гэм буруутай нөхцөлд энэ зүйлийн 2 дах мөрд заасан зөрчлийн улмаас учирсан хохирол, зардлыг илгээмжийн үйлчилгээ эрхлэгчид нөхөн төлнө гэсэн байна.<sup>89</sup> Тээвэр зууч нь өөрийн хамгаалалтад байгаа бараа гээгдсэн эсвэл эвдэрч гэмтсэний улмаас учирсан хохирлыг хариуцан арилгана гэж заасан байна. Энэ хуулийн §426, 427, 429, 430, 431<sup>90</sup> Abs. 1,2,4 болон §§ 432<sup>91</sup>, 434-436<sup>92</sup>-г төсөөтэй хэрэглэнэ.<sup>93</sup>

Дараагийн тээвэр зуучийн хувьд өмнөх тээвэрлэгч эсвэл тээвэр зуучлагчийн шаардлагыг дараачийн тээвэр зууч хангасан бол эхний тээвэр зуучийн шаардах эрх ба

<sup>86</sup> Ibid §434(1).

<sup>87</sup> Ibid §434(2).

<sup>88</sup> Ibid §455(2).

<sup>89</sup> Ibid §455(3).

<sup>90</sup> Хариуцлагын дээд хэмжээ.

<sup>91</sup> Бусад зардлыг нөхөн төлөх.

<sup>92</sup> §432-Бусад зардлыг нөхөн төлөх, §433-Бусад хөрөнгийн хохирлыг хариуцах хариуцлагын дээд хэмжээ, §434-Гэрээний бус шаардах эрхүүд, §435-Хариуцлагаас чөлөөлөх, хязгаарлах зохицуулалт хүчингүй болох, §436-Бусдын өмнөөс хариуцлага хүлээх.

<sup>93</sup> Ibid §461(1).



барьцааны эрхтэй холбоотой эрхүүд дараачийн тээвэр зуучлагчид шилжинэ.<sup>94</sup>

ХБНГУ-ын *Тээвэр Зуучийн Стандарт Нөхцөл (2017)-ийн 22.2*-т зааснаар “Тээвэр зууч ачаа тээврийн алдагдал, эвдрэлд гэм буруутай бол Арилжааны хуулийн 429, 430 болон 432 дүгээр зүйлд заасны дагуу хохирол, учирсан гэм хорын үнэ, түүнээс үүдэн гарсан зардлыг нөхөн төлөх ёстой гэж заасан байна.

### 1.3.2. БНФУ

Франц Улсын Иргэний хууль (*Civil Code*)-д ерөнхий байдлаар гэрээнээс үүсэх үүрэг, үүргийн зөрчил, хохирол шаардах эрхийн талаар зохицуулсан байна.

Иргэний хуулийн 1217 дугаар зүйлд “Гэрээний аль нэг тал үүргээ гүйцэтгээгүй эсхүл дутуу гүйцэтгэсэн тохиолдолд гэрээний нөгөө тал өөрийн үүргээ биелүүлэхээс татгалзах, үүргээ биелүүлээгүй эсхүл дутуу гүйцэтгэсэн талаас үүргээ гүйцэтгэхийг шаардах, үнэ бууруулах шаардлага гаргах, гэрээ цуцлах, үүрэг гүйцэтгээгүйгээс учирсан хохирлыг арилгахыг шаардах эрхтэй” гэж гэрээнээс үүсэх талуудын үүргийг ерөнхий байдлаар хуульчилж хохирол барагдуулах тухай шаардах эрхийн хязгаарыг хуулийн 1231-2 дугаар зүйлд “Хуульд өөрөөр заагаагүй бол хариуцагчийн барагдуулах хохирол нь гэрээний эсрэг талд үүссэн алдагдал болон түүний ирээдүйд олох боломжтой байсан ашгийг хамарна” гэж тусгаснаас үзвэл гэрээний аль нэг тал үүргээ гүйцэтгээгүйгээс учирсан бодит хохирлоос гадна ирээдүйд олох байсан орлого, ашгийг хамааруулж нэхэмжлэлийн шаардлага гаргаж болохоор зохицуулалт байна.

Түүнчлэн энэхүү хариуцлагыг гэрээний талуудын гэм буруутай холбон тайлбарлаж хуулийн 1231-3 дугаар зүйлд “Гэрээний харилцаанаас үүссэн хохирлын хариуцагч нь санаатайгаар хохирол учруулснаас бусад тохиолдолд зөвхөн гэрээ байгуулагдах үед тооцоологдсон эсхүл тооцоолох боломжтой байсан хохирлыг хариуцна” гэсэн нь үүргийн зөрчлөөс үүдэн гэм буруугийн аль нэг хэлбэр байхгүйгээр учирсан хохиролд гэрээний талыг хариуцлагаас чөлөөлөх агуулгатай байна.

Дээрх шаардах эрхийг хязгаарлах нөхцөлийг гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлтэй холбон тайлбарлах үүднээс хуулийн 1218 дугаар зүйлд “Давагдашгүй хүчин зүйл нь гэрээний харилцаанд, үүрэг гүйцэтгэгч гэрээний тал үүргээ биелүүлэхэд саад болж буй, гэрээ хийгдэх үед урьдчилан таамаглах боломжгүй байсан, үр нөлөөгөөс нь зайлсхийх боломжгүй нөхцөл байдлыг хэлнэ” гэж хуульчилсан.

### 1.3.3. ЯПОН УЛС

Арилжааны хуулийн 579 дүгээр зүйлд олон тээвэрлэгч байгаа тохиолдолд тухайн этгээдүүдийн эрх, үүргийн талаар хуульчилжээ. Тодруулбал, олон тээвэрлэгч дараалан /дамжуулан/ газраар ачаа тээвэрлэх тохиолдолд, барааг хүлээж авч буй тээвэрлэгч нь өмнөх тээвэрлэгчтэй солигдож, эрх эдэлж, үүрэг хүлээнэ. Харин ачааны зарим хэсгийг өөр тээвэрлэгчээр илгээсэн, өөрөөр хэлбэл олон тээвэрлэгчид зэрэг барааг тээвэрлэсэн тохиолдолд, тээвэрлэгч бүр бараа үрэгдсэн зэрэг нөхцөл байдалд хамтарсан хариуцлагыг үүрнэ (Арилжааны хуулийн 579 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг).

Тухайн харилцаанд олон тээвэрлэгч оролцсон байх тохиолдолд ямар хэлбэрээр гэрээгээ байгуулснаас шалтгаалан 4 өөр төрлийн гэрээ Япон улсад хийгддэг бөгөөд тухайн гэрээний хэлбэрээсээ шалтгаалан хохирол, учирсан гэм хороо хэнээс шаардах, хэн хариуцлага хүлээх гэдэг нь өөр өөр байна.

<sup>94</sup> *Ibid.* §465(2)



### **Дараалсан тээвэрлэлтийн гэрээ (相次運送).<sup>95</sup>**

Ачаа илгээгч тээвэрлэгчтэй гэрээ хийж, тухайн тээвэрлэгч нь тээвэрлэлтийн тодорхой замыг туулсны дараа өөр нэгэн тээвэрлэгчид ачааг шилжүүлэн, ачааг шилжүүлэн авсан тээвэрлэгч тээвэрлэлтийн үлдсэн замыг туулж ачааг хүлээн авагчид шилжүүлэн өгөх гэрээний хэлбэр юм. Энэ тохиолдолд ачаа илгээгч, нэгдүгээр тээвэрлэгч гэх хоёр этгээдийн хооронд тээвэрлэлтийн гэрээ байгуулагдах ба уг гэрээний харилцаа үргэлжлэн хоёрдугаар тээвэрлэгчид хамаарах учир хоёрдугаар тээвэрлэгчийн хувьд ачаа илгээгчийн өмнө хариуцлага хүлээнэ.

Ачаа тээвэрлэх явцад ачаа гэмтэж, үрэгдэх, эсхүл хугацаа хожимдуулсан бол нэгдүгээр тээвэрлэгч ачааг тээвэрлэх явцад тухайн гэм хор үүссэн үү? хоёрдугаар тээвэрлэгч ачааг тээвэрлэх явцад тухайн гэм хор үүссэн үү? эсэх нь тодорхойгүй байсан ч ачаа илгээгч нь аль алинийх нь эсрэг хохирлоо шаардаж болох буюу хамтран хариуцлага (連帶責任) хүлээнэ.

### **Туслан гүйцэтгэх тээвэрлэлтийн гэрээ (下請運送).**

Нэгдүгээр тээвэрлэгч, хоёрдугаар тээвэрлэгчид тээвэрлэлтийн үлдсэн замыг туулж ачааг хүлээлгэн өгөхдөө хоёрдугаар тээвэрлэгчтэй туслан гүйцэтгэх гэрээ (下請契約) байгуулах хэлбэрээр тээвэрлэлтийг гүйцэтгэх гэрээний хэлбэр. Энэ тохиолдолд ачаа илгээгч, хоёрдугаар тээвэрлэгч гэх хоёр этгээдийн хооронд гэрээний харилцаа үүсэхгүй.

Ачаа тээвэрлэх явцад ачаа гэмтэж, үрэгдэх, эсхүл хугацаа хожимдуулсан тохиолдолд нэгдүгээр тээвэрлэгчийн буруугаас болсон бол мэдээж нэгдүгээр тээвэрлэгч хариуцлагаа хүлээнэ харин хоёрдугаар тээвэрлэгчийн буруугаас болсон бол нэгдүгээр тээвэрлэгч илгээгчийн өмнө хариуцлага хүлээнэ. Энэ онцлогоороо дараалсан тээвэрлэлтийн гэрээнээс ялгаатай.

### **Хуваагдмал тээвэрлэлтийн гэрээ (分割運送)**

Ачаа илгээгч тодорхой цэг хүртэлх тээвэрлэлтийг нэгдүгээр тээвэрлэгчтэй, тээвэрлэлтийн үлдсэн замыг туулахыг хоёрдугаар тээвэрлэгчтэй тус тусд нь тээвэрлэлтийн гэрээ хийх хэлбэр. Энэ тохиолдолд тээвэрлэгчид зөвхөн өөрсдийн гэм буруугаас үүдсэн хохирлыг арилгах хариуцлагаа ачаа илгээгчийн өмнө хүлээнэ.

### **Хамтын тээвэрлэлтийн гэрээ (同一運送)**

Ачаа илгээгч тээвэрлэлтийн гэрээг нэг, хоёрдугаар тээвэрлэгчтэй хийж гэрээний үүргийг хамтран гүйцэтгэх үүрэг хүлээлгэх хэлбэр.

Энэ тохиолдолд нэг, хоёрдугаар тээвэрлэгч хоорондоо хэлэлцэн ачааны хувиарлалтыг өөрсдөө шийднэ.

Ачаа тээвэрлэх явцад ачаа гэмтэж, үрэгдэх, эсхүл хугацаа хожимдуулсан тохиолдолд илгээгчийн өмнө хариуцлагыг хамтран хүлээнэ.

**ГЭРЭЭНИЙ ҮҮРЭГТЭЙ ХОЛБООТОЙ ХАРИЛЦААНААС ҮҮСЭХ НЭМЭЛТ ҮҮРЭГ /ЖИШЭЭ НЬ: МЭДЭЭЛЭЛ ӨГӨХ ҮҮРЭГ/**

#### **1.4.1. ХБНГУ**

ХБНГУ нь гэрээний үүрэгтэй холбоотой харилцаанаас үүсэх нэмэлт үүргийг

<sup>95</sup> 前掲注 (44) 218-219 頁。



зохицуулсан ба *тээвэрлэлтийн гэрээ*ний хувьд Арилжааны хуульдаа ачаа тээвэрлэх нөхцөлд илгээгчийн мэдэгдэх үүргийг зохицуулж өгсөн байна. Үүнд:

- Аюултай ачааг тээвэрлэх нөхцөлд илгээгч нь ачаа тээвэрлэгчид аюултай нөхцөл байдлын талаар, мөн шаардлагатай тохиолдолд авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар эх текст хэлбэрээр мэдэгдэнэ<sup>96</sup>.
- Тээвэрлэгч нь барааг хүлээн авах үед аюултай нөхцөл байдлын талаар мэдээгүй эсвэл энэ талаар мэдэгдэл хүлээн аваагүй бол<sup>97</sup>:
  1. Илгээгчид хохирлыг нөхөн төлөлгүйгээр аюултай барааг буулгах, хадгалах, буцааж тээвэрлэх, шаардлагатай бол устгах эсвэл аюулгүй болгох эрхтэй.
  2. Илгээгчээс эдгээр арга хэмжээ авахад гарсан зайлшгүй зардлыг гаргуулах эрхтэй.

Харин *илгээмжийн/тээвэр зуучийн гэрээ*ний хувьд “Ачаа илгээгч нь барааг савлаж баглан тэмдэглэгээ хийх ба холбогдох баримт бичгийг дагалдуулах, мөн илгээмжийн үйлчилгээ эрхлэгч тээвэрлэлтийг зохион байгуулахад шаардагдах бүх мэдээллийг олгох үүрэгтэй. Аюултай ачаа илгээх нөхцөлд илгээгч нь илгээмжийн үйлчилгээ эрхлэгчид зохих хугацаанд багтаан нүүрлэж болох аюул, арга хэмжээний талаар эх текст хэлбэрээр бичиж өгнө.”<sup>98</sup>

Мөн түүнчлэн ХБНГУ-ын Тээвэр Зуучийн Стандарт Нөхцөл (2017)-д зааснаар тээвэр зуучийг үүргээ гүйцэтгэх зуур аливаа саад бэрхшээл, *force majeure* (гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдал) үүсэх үед “Тээвэр зууч нь ачаа барааг хүлээн авах боломжгүй, эсхүл хугацаанд нь хүлээн авах боломжгүй бол үүрэг гүйцэтгүүлэгч буюу илгээгчид нэн даруй мэдэгдэж, түүнээс заавар, чиглэлийг авах ёстой.”<sup>99</sup>

Гэрээний талуудын үүрэг, хариуцлагын хүрээнд хамаарахгүй саад бэрхшээл үүсэх тохиолдолд талууд үүнд хамаарах үргэлжлэх хугацаа болон нөлөөллийн хэмжээгээр үүргийн гүйцэтгэлээс чөлөөлөгдөнө. Үүргийн гүйцэтгэлийг үргэлжлүүлэх боломжгүй нөхцөл байдалд гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл, иргэдийн үймээн самуун, дайн ба терроризмын үйлдэл, ажил хаялт, хорио, тээврийн замыг хаах, урьдчилан таамаглах болон зайлсхийх боломжгүй, ноцтойд тооцогдох үйл явдлууд хамаардаг. *Үүргийн гүйцэтгэлд саад бий болсон тохиолдолд гэрээний талууд нөгөө талдаа нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.* Мөн тээвэр зууч нь илгээгчээс заавар авах үүрэгтэй.<sup>100</sup>

Хэрэв тээвэр зууч нь ачааг хилээр тээвэрлэх, импорт, экспортын гаалийн бүрдүүлэлт хийх үүрэг хүлээсэн бол тээвэр зууч нь эргэлзэж байвал ийм арга хэмжээ авалгүйгээр ачааг тохиролцсон газар хүртэл тээвэрлэх боломжгүй болсон тохиолдолд ачааг гаалийн болон хуулиар тогтоосон бусад зохицуулалттай холбоотой үйл ажиллагаа явуулах эрхтэй байна.<sup>101</sup>

<sup>96</sup> *Ibid* §410(1).

<sup>97</sup> *Ibid* §410(2).

<sup>98</sup> *Ibid* §455(1).

<sup>99</sup> GERMAN FREIGHT FORWARDERS' STANDARD TERMS AND CONDITIONS(2017), 12.1., [https://www.gw-world.com/fileadmin/Country\\_Documents/DE\\_documents/Imprint-Memmingen/ADSp-2017-EN.pdf](https://www.gw-world.com/fileadmin/Country_Documents/DE_documents/Imprint-Memmingen/ADSp-2017-EN.pdf) (Сүүлд үзсэн: 2023. 07.01). Үүний дагуу ХБНГУ-ын Арилжааны хуулийн §419 дүгээр зүйл хамаарах ба илгээгч нь тээвэр зуучлалын гэрээг цуцлах эрхтэй хэвээр байгаа бол тээвэр зууч нь хуулийн §415(2)-д заасан хэсгийн дагуу нөхөн төлбөрийг шаардах эрхгүй болно.

<sup>100</sup> *Ibid* 12.2.

<sup>101</sup> *Ibid* 4.6.



## 1.4.2. БНФУ

Тээвэр зуучийн гэрээний агуулгыг тодорхойлох буюу гэрээний харилцаанд талуудын чөлөөт байдлыг хангах зорилгоор гэрээний агуулгыг хуульд харшлахаас бусад тохиолдолд талууд харилцан зөвшилцөж, гэрээ байгуулахаар тохиролцож болно. Гэсэн хэдий ч амьдрал дээр зарим тохиолдолд талууд бичгээр гэрээ байгуулаагүй, гэрээгээр хүлээх үүргээ тодорхойлоогүй гэрээ байгуулсан байх тохиолдлууд гардаг. Энэ тохиолдолд талуудын хоорондын харилцааг хамгаалах зорилгоор Тээврийн хуулийн (Code Des Transports) 1432-4 болон 1432-12 дугаар зүйлд “талууд гэрээгээр тохиролцоогүй тохиолдолд тээвэрлэлтийн гэрээний жишгийг дагаж мөрдөнө” гэж заасан.

Энэхүү заалтыг шүүхийн шийдвэрээр “хэрэв талуудын хооронд байгуулсан гэрээнд хуульд нийцээгүй заалт байх тохиолдолд тээвэрлэлтийн гэрээний жишгийн заалтуудаар нөхөн зохицуулж хэрэглэж болно” гэж тодруулж, практик тогтоожээ.

Тус Тээврийн гэрээний жишиг нь 2017 оны 3 сарын 31-ний Ерөнхий сайдын тогтоолоор шинэчлэгдэн батлагдсан ба гэрээний онцлох зохицуулалтаас доорх байдлаар үзүүлбэл:

<p><b>1 дүгээр зүйл. Зохицуулах харилцаа ба хамрах хүрээ</b>  Энэхүү гэрээ нь тээвэр зууч нь тээвэрлэлтийг хэрхэн зохион байгуулах нөхцөлүүдийг заана. Тээвэрлэлтийн төрлөөс үл шалтгаалан энэхүү гэрээ нь үүрэг гүйцэтгүүлэгч болон тээвэр зуучийн хооронд эсхүл анхдагч тээвэр зууч болон тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцсон тээвэр зууч нарын хоорондын харилцааг зохицуулна. Үүрэг гүйцэтгүүлэгч болон тээвэр зуучийн хоорондын харилцаа нь бичгээр хийсэн гэрээнээс үүссэн худалдааны харилцаа бол тээвэрлэлт бүр энэ гэрээний нөхцөлийг хангасан гэж үзнэ.</p>
<p><b>2 дугаар зүйл. Нэр томъёоны тайлбар</b>  <b>2.2. Тээвэр зууч</b>  Үүрэг гүйцэтгүүлэгч (захиалагч “donneur d'ordre”)-ийн нэрийн өмнөөс барааг өөрийн сонгосон арга, хэрэгслээр барааг нэг газраас нөгөөд шилжүүлэх ажлыг өөрийн хариуцлага, нэрийн өмнөөс чөлөөтэй зохион байгуулж, гүйцэтгэж байгаа аливаа үйлчилгээ үзүүлэгч.  <b>2.3. Үүрэг гүйцэтгүүлэгч</b>  Тээвэр зуучтай гэрээ байгуулсан тал (илгээгч).</p>
<p><b>3 дугаар зүйл. Үүрэг гүйцэтгүүлэгчийн хүлээх үүрэг</b>  <b>3.1. Тээвэр зуучид өгөх мэдээлэл ба баримт бичиг</b>  Тээвэрлэлтийг зохих ёсоор зохион байгуулах, үүрэг хугацаандаа гүйцэтгэхэд зориулж үүрэг гүйцэтгүүлэгч нь илгээлт бүрд бичгээр эсвэл цахимаар дараах мэдээллүүдийг явуулна:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Тээвэрлэлтийн шинж чанар, зорилго;</li> <li>2. Онцгой нөхцөл;</li> <li>3. Хаяг, он сар болон шаардлагатай бол бараа хүргэгдэн очих хугацаа;</li> <li>4. Илгээгчийн болон хүлээн авагчийн нэр;</li> <li>5. Илгээмжийн тоо эсхүл жин, шаардлагатай бол хэмжээ, болон барааны шинжийн талаар маш тодорхой тодорхойлсон байх;</li> <li>6. эдгээрийн болзошгүй аюул;</li> <li>7. Дагалдах үйлчилгээний талаар (үнийн мэдүүлэг, барааны даатгал, гаалийн үйл ажиллагаа зэрэг);</li> <li>8. бусад тусгай заавар.</li> </ol> <p><b>3.2. Хуулиар тээвэрлэхийг хориглосон бараа.</b>  Үүрэг гүйцэтгүүлэгч нь хууль бус, хориотой барааг тээвэрлэх ажлыг зохион байгуулахыг тээвэр зуучид даалгахыг хориглоно.  <b>3.3. Тээврийн хэрэгсэл.</b>  Үүрэг гүйцэтгүүлэгч нь ямар нэг тусгай тээвэрлэлтийн хэрэгсэл тээвэрлэлтэд шаардагдах бол үүнийгээ тодорхойлж бичгээр эсвэл цахимаар хүсэлтээ тээвэр зуучид илгээнэ.</p>



3.4. Тээвэр зуучийн үүрэг, 5 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд, үүрэг гүйцэтгүүлэгч нь худал, алдаатай, дутуу, тохиромжгүй мэдээлэл, мэдүүлэг өгсөнтэй эсхүл зуучлагчид оройтон хүлээлгэн өгсөнтэй холбоотой үр дүнг хариуцна.

#### **4 дүгээр зүйл. Бараа бүтээгдэхүүнийг баглах, хаяглах**

4.1. Бараа бүтээгдэхүүний шинжээс хамааран шаардагдаж байвал үүрэг гүйцэтгүүлэгч нь барааг бэлдэж, баглаж, хаяглаж тээвэрлэлт болон хадгалах нөхцөл байдлыг тэсвэрлэх боломжтой болгон өгнө.

4.3. Тусгай зохицуулалттай бараа бүтээгдэхүүний хувьд үүрэг гүйцэтгүүлэгч нь баглаан дээр заавал тавигдах тэмдэг, маркийг нааж, тээвэр зуучид барааны шинжийн талаар бичгээр эсхүл цахимаар анхааруулна.

4.6. Илгээмж нь хүн болон бусад тээвэрлэж буй бараа бүтээгдэхүүн түүнчлэн тээвэрлэлтийн машин, хэрэгсэлд аюул учруулж болохгүй.

4.7. Хэрэв тээвэр зууч нь бараа бүтээгдэхүүний сав, баглаа, боодол эсхүл хаяглалтад алдаа гарсныг мэдсэн бол тэр даруйд үүрэг гүйцэтгүүлэгчид бичгээр эсхүл цахимаар түүнээс зааварчилгаа авахын тулд мэдэгдэнэ.

#### **5 дугаар зүйл. Тээвэр зуучийн үүрэг**

##### **5.1. Үүргийн шинж чанар**

Тээвэр зууч нь барааг зөрчилгүй тээвэрлэх хариуцлага хүлээнэ. Тэрээр үйл ажиллагааг үүрэг гүйцэтгүүлэгчийн өгсөн мэдээлэл, хүсэлт, зааварчилгаанд тулгуурлан зохион байгуулна.

##### **5.2. Баримт бичгийг шалгах**

Тээвэр зууч нь үүрэг гүйцэтгүүлэгчийн өгсөн тээвэрлэлтийн зохион байгуулалттай шууд холбоотой бичиг баримтуудыг шалгана. Бусад бичиг баримтуудын хувьд өөрт нь өгөгдсөн даалгавартай нийцэж байгаа эсэхийг шалгана.

##### **5.3. Тээвэрлэлтэд шаардлагатай бичиг баримтуудыг боловсруулах, шалгах**

Тээвэр зууч нь тээврийн баримт бичгийг бүрдүүлэх, барааг тээвэрлэхэд шаардлагатай мэдээлэл, баримт бичгийг өөрт нь өгсөн, эсхүл тээвэрлэгч(үүд)-д хүлээлгэн өгөхөөс хоцорсон эсэхийг шалгана. Тэрээр өөрөөс нь шаардлагатай бичиг баримтуудыг боловсруулах бөгөөд өөрийн бололцоогоор бусдаас гарах шаардлагатай бичиг баримтууд гарсан эсэхийг хянана.

##### **5.4. Тээвэр зуучийн мэдээлэл өгөх үүрэг**

5.4.1. Үүрэг гүйцэтгүүлэгчийн өгсөн мэдээлэл эсхүл зааварчилгаа тодорхой бус, тохиромжгүй, дутуу эсхүл тээвэрлэлтийг зөв явуулахад саад болохоор байвал тээвэр зууч нь үүрэг гүйцэтгүүлэгчээс нэмэлт мэдээллийг бичгээр эсхүл цахимаар хүснэ.

5.4.2. Үүрэг гүйцэтгүүлэгчийн зааварчилгаа хэрэгжиж буй дүрэм журамтай нийцэхгүй эсхүл ямар нэг байдлаар эрсдэл үүсгэхээр байвал зууч нь түүнийг хэрэгжүүлэхээс татгалзах ёстой. Үүнийгээ үүрэг гүйцэтгүүлэгчид бичгээр эсхүл цахимаар мэдэгдэнэ.

##### **5.4.3. Тээвэр зууч нь үүрэг гүйцэтгүүлэгчид тээвэрлэлт дамжин өнгөрөх улс орнуудын дүрэм журам мөн тээвэрлэлттэй холбоотой гэрээ конвенцын талаар мэдэгдэнэ.**

##### **5.5. Зөвлөгөө өгөх үүрэг**

5.5.1. Тээвэр зуучийн гэрээг байгуулахаас өмнө тээвэр зуучлагч үүрэг гүйцэтгүүлэгчид тээвэрлэлтэд ашиглагдах арга хэлбэрийн талаар давуу болон сөрөг талуудыг тайлбарлана.

5.5.2. Үүрэг гүйцэтгүүлэгчээс өгсөн барааны шинж, үнэ болон бараа илгээгдэх газар, илгээгдэхээр тохиролцсон хугацаа, барааны зах зээлийн онцлогийн талаар мэдээллийг харгалзан тээвэр зууч нь барааны даатгал, үнийн мэдүүлэг, хүргэлтийн илүү төлбөр зэргийг санал болгоно.

##### **5.7. Үйл ажиллагааны үйл явц болон хүргэлттэй холбоотой үүргүүд**

5.7.1. Тээвэр зууч нь үйл ажиллагааны үйл явц болон хүргэлттэй холбоотой аливаа мэдээллийг мэдсэн дариудаа үүрэг гүйцэтгүүлэгчид мэдэгдэнэ.

5.7.2. Тээвэр зууч нь гэрээг гүйцэтгэх явцад гарсан хүндрэлийн талаар үүрэг гүйцэтгүүлэгчид мэдэгдэнэ.

5.8. Тээвэр зууч үүрэг даалгавраа биелүүлээгүй бол үүргээ биелүүлээгүйн улмаас учирсан үр дагаврыг 13 дугаар зүйлд заасны дагуу хариуцна.



**9 дүгээр зүйл. Үүрэг гүйцэтгүүлэгчийн (илгээгчийн) үүргийн зөрчил, тээвэрлэлтийн саад**  
Үүрэг гүйцэтгүүлэгч нь тээвэр зуучид тээвэрлэлтийн арга, хоорондын мэргэжлийн харилцаанд тогтсон хэрэглээг харгалзан хангалттай хугацааны өмнө, барааг тохиролцсон цагтаа хүлээлгэн өгөх боломжгүй болсон бол түүнийгээ мэдэгдэнэ.  
Мэдэгдээгүй тохиолдолд тээвэр зуучлагч үүнээс үүссэн, гэрээ байгуулах үед таамаглах боломжтой байсан хохирлоо нэхэмжлэх эрхтэй.  
Хэрэв аливаа бараа нь ачигдсаны дараа тээвэрлэлт саатсан эсхүл түр хугацаанд зогссон эсхүл тээвэрлэх боломжгүй болсон тохиолдолд тээвэр зууч үүрэг гүйцэтгүүлэгчээс өгсөн зааварчилгааг бичиг эсхүл цахимаар шаардана.  
Тээвэр зууч нь үүрэг гүйцэтгүүлэгчид энэхүү саатлаас үүссэн өөрийн мэдэх бүх үр дүнг мэдээлнэ.  
Хэрэв үүрэг гүйцэтгүүлэгчээс боломжит хугацаанд хариу ирээгүй бол тээвэр зууч нь түүнд ашигтай байх бүхий л арга хэмжээг авна.  
Энэхүү илүү зардлуудыг үүрэг гүйцэтгүүлэгч хариуцна.  
Хэрэв тээвэрлэлтэд учирсан саад үүрэг гүйцэтгүүлэгчээс үүдэлтэй бол тээвэр зууч нь энэхүү саатлаас учирсан илүү зардлыг үүрэг гүйцэтгүүлэгчээс шаардах эрхтэй.

**13 дугаар зүйл. Талуудын хариуцлага**

Тээвэр зууч нь тээвэрлэлт, тээвэрлэлтийн зохион байгуулалт, гүйцэтгэлээс учирсан хохиролд хариуцлага хүлээнэ.  
Нотлогдсон болон урьдчилан таамаглах боломжтой хохирлыг дараах нөхцөлөөр барагдуулна:  
13.1. Тээвэрлэлтэд оролцогчдоос үүдсэн хариуцлага (Responsabilité du fait des substitués.)  
Энэхүү тээвэрлэлтэд оролцогчдоос үүссэн, нотлогдсон хохирлыг барагдуулах тээвэр зуучийн хариуцлага нь түүнд хүлээлгэн өгсөн тээвэрлэлтийн даалгавартай холбоотой үйл ажиллагаанаас үүссэн хохирлоор хязгаарлагдана.  
13.2. Тээвэр зуучлагчийн хувийн хариуцлага  
Санаатай эсхүл өршөөх аргагүй (ou inexcusable) алдаанаас бусад тохиолдолд тээвэр зуучийн хувийн алдаанаас үүдэлтэй хохирлыг барагдуулах хэмжээ нь дараах байдлаар хязгаарлагдана:  
13.2.1. Барааны алдагдал ба гэмтэл  
Тээвэр зуучийн барагдуулах хохирол нь алдагдсан эсхүл гэмтсэн барааны киллограм жинг 20 еврогоор үржүүлсэнтэй тэнцэнэ.  
13.2.2. Хоцрогдол  
Хүргэлт хойшилсны улмаас үүссэн хохирлыг барагдуулах хэмжээ нь тээвэр зуучийн үйл ажиллагааны зардлаар хязгаарлагдана. (татвар, төрөл бүрийн зардлыг оруулахгүйгээр)

Дээрх Тээврийн гэрээний жишиг буюу талууд бичгээр гэрээ хийгээгүй тохиолдолд талуудыг хамгаалах зорилгоор байгуулагдсанд тооцох, бичгээр хийсэн гэрээний заалт нь хууль зөрчсөн тохиолдолд түүнийг нөхөн зохицуулах хэм хэмжээ болж тухайн харилцаанд үйлчилдэг тус баримт бичигт гэрээний талуудын хүлээх эрх, үүрэг, хохирол шаардах эрхийг нэлээд дэлгэрэнгүй байдлаар зохицуулжээ.

Ингэхдээ тээвэрлэгдэж байгаа барааг аюулгүй тээвэрлэх талаар боломжит бүх арга хэмжээг авах, тээвэрлэлт дамжин өнгөрөх улс орнуудын дүрэм журам мөн тээвэрлэлттэй холбоотой гэрээ конвенцын талаар мэдэгдэх үүрэг тээвэр зуучид, мэдээллийн дагуу баримт бичгийг бэлтгэж илгээх буюу тухайн барааг дагалдах баримт бичиг болох гаалийн бичиг, тээвэрлэлтийн бичиг болон бусад хэрэгцээт баримт бичиг мэдээллийг өгөх үүрэг, барааг тээвэрлэх боломжит нөхцөлд бэлтгэх, боох, баглах үүргийг нь тухайн барааг илгээгч буюу үүрэг гүйцэтгүүлэгч гүйцэтгэнэ.

Түүнчлэн талууд бичгээр тээвэр зуучийн гэрээ хийж тээвэр зууч нь аливаа хохирлыг арилгах эрхийг шилжүүлэн авснаас бусад тохиолдолд болон давагдашгүй хүчин зүйл үүссэн тохиолдолд хариуцлагаас чөлөөлөгдөхөөр байна. Харин бусад тохиолдолд аливаа эрсдэл Худалдааны хуулийн зохицуулалтын дагуу тухайн тээвэрлэгдэж байгаа барааг эзэмшигчид эрсдэл, хариуцлага шилжинэ.



### 1.4.3. ЯПОН УЛС

Ачаа тээвэрлэхтэй холбогдуулан ачаа барааны тухай нэмэлт мэдээлэл өгөх үүргийн (通知義務-мэдэгдэх үүрэг) талаар хуульд дараах хоёр тохиолдлыг тусгайлан тусгасан байна.

#### Аюултай бараа (危険物)

Арилжааны хуулийн 572 дугаар зүйлд заасны дагуу илгээгч нь ачаа, бараа нь шатамхай (引火性), дэлбэрэх аюултай (爆発性) болон бусад байдлаар аюултай (危険性) шинжийг агуулж байгаа тохиолдолд энэ тухай болон тухайн ачааны нэр, шинж чанар, тус ачааг аюулгүй тээвэрлэхтэй холбоотой бусад мэдээллийг тээвэрлэгчид хүлээлгэн өгөхийн өмнө (引渡しの前) мэдэгдэх үүрэгтэй (通知義務).

Мэдэгдэх үүргийн тухай зохицуулалт нь 2019 оны 04 сарын 01-ны өдөр Арилжааны тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр шинээр орсон шинэлэг зохицуулалт юм. Уг мэдэгдэх үүрэг нь авто зам, төмөр зам, далайн тээвэр, агаарын тээвэр зэрэг бүх төрлийн тээвэрлэлтэд хамааралтай юм.<sup>102</sup>

#### Үнэ бүхий бараа (高価品)

Арилжааны хуулийн 577 дугаар зүйлд мөнгө (貨幣) болон үнэт цаас (有価証券) бусад үнэт зүйлсийг илгээгч нь тээвэрлэлт хийлгэхдээ тухайн барааны төрөл болон үнийг мэдэгдээгүй тохиолдолд тээвэрлэгч нь хохирлыг хариуцахгүй гэж заасан байна. Өөрөөр хэлбэл, үнэт зүйлийн талаар илгээгч нь ямар нэгэн мэдээлэл өгөөгүй тохиолдолд, тээвэрлэгч нь тухайн бараа алга болсон зэргээр учирсан хохирлыг арилгах үүрэг үүсэхгүй.<sup>103</sup> Уг зүйлд заасан “үнэт зүйл (高価品)” гэдэг нь үнэт чулуу (宝石), алтан эдлэл (貴金属) зэрэг үнэт зүйлсийг ойлгох бөгөөд харагдах хэмжээ болон багтаамжаасаа илүү өндөр үнэтэй зүйл байна.<sup>104</sup> Харин үнэт зүйлсийн талаар мэдэгдэл байгаагүй хэдий ч тээвэрлэгч нь тэр талаар мэдэж байсан бол тээвэрлэгч хариуцлага хүлээх эсэхэд судлаачид ялгаатай байр суурийг илэрхийлдэг.<sup>105</sup>

<sup>102</sup> 商法改正にともなう危険物運送の通知義務, [MSIMarineNews20190306.pdf \(ms-ins.com\)](https://www.ms-ins.com/MSIMarineNews20190306.pdf).

<sup>103</sup> 前掲注 (37) 172頁。

<sup>104</sup> 最判昭和45年4月21日判時593号87頁。

<sup>105</sup> 前掲注 (37) 172頁。



## ДҮГНЭЛТ

Энэхүү судалгааны ажлын хүрээнд тээвэр, тээвэр зуучийн гэрээ ба уг гэрээний эрх зүйн харилцаатай холбоотой онцлог зохицуулалтуудыг онолын хүрээнд хэрхэн ойлгодог талаар судлан, тус ойлголтуудын агуулгыг ХБНГУ, БНФУ болон Япон Улсын зохицуулалтаас харьцуулан судалсны үр дүнд дараах дүгнэлтэд хүрэв:

**ХБНГУ-ын эрх зүйн зохицуулалтын тухайд:** ХБНГУ нь Арилжааны хуульдаа тээвэртэй холбоотой тээвэрлэлтийн, илгээмжийн буюу тээвэр зуучийн, комиссын, хадгалалтын гэрээ, худалдааны төлөөлөгч, худалдааны зуучлагч гэсэн 6 төрлийн гэрээний харилцааг зохицуулж өгчээ. Эдгээр гэрээний төрлүүдийг илүү нарийвчлан судлахад, тээвэрлэлтийн гэрээ нь 3 төрөлтэй ба үүнд ердийн *тээвэрлэлтийн гэрээ, нүүлгэх гэрээ, олон төрлийн тээврийн хэрэгслээр ачаа тээвэрлэх гэрээ хамаардаг* байна. Харин илгээмжийн гэрээг агуулгын хүрээнд тээвэр зуучийн гэрээтэй адилтган авч үздэг.

ХБНГУ-ын тээвэрлэлтийн гэрээнд, тээвэрлэгч нь илгээгчийн шаардлагаар эсхүл түүнд ийнхүү шалгах хангалттай хэрэгсэл бий нөхцөлд жин, тоо хэмжээ, агуулгыг шалгах үүрэгтэй бөгөөд шалгалт хийхэд гарсан холбогдох зардлыг нөхөн төлүүлэх эрхтэйгээс гадна тээвэрлэгч нь барааг тохирсон газарт хүргэж, хүлээн авагчид хүлээлгэн өгөх үүрэгтэй.

Харин илгээмжийн/тээвэр зуучийн гэрээн дэх тээвэр зуучийн үйлчилгээ эрхлэгч нь барааг илгээх үүрэг хүлээнэ. Өөрөөр хэлбэл, барааг илгээх үүрэг гэдэгт тээвэрлэлтийг зохион байгуулах буюу тээврийн хэрэгсэл ба тээврийн замыг тодорхойлох, гүйцэтгэгчийг сонгох, гүйцэтгэгчид мэдээлэл, зааварчилгаа өгөх гэх мэтээр илгээгчийн өмнөөс тээвэрлэлттэй холбогдох даатгал, барааг баглах, боох, тэмдэглэгээ хийх зэрэг бусад үүргийг хийж гүйцэтгэдэг талаар нэлээд дэлгэрэнгүй байдлаар зохицуулсан байна.

Мөн түүнчлэн ХБНГУ нь авто зам, төмөр зам, агаарын тээврийн харилцааг тус тусдаа бие даасан хууль болон холбогдох олон улсын гэрээ, конвенцоор зохицуулдаг онцлогтой. Эдгээр тээврийн гэрээнүүдэд ачааг тээвэрлэх тохиолдолд голлох үүрэг гүйцэтгэж буй субъект нь илгээгч байх бөгөөд жишээ нь: авто замын тээврийн гэрээнд “ачааны баглаа боодлын тэмдэглэгээ, дугаар хангалттай бус байх тохиолдолд ачаанд гэмтэл, хохирол учирвал түүнийг тээвэрлэгч хариуцахгүй”, төмөр замын тээврийн гэрээнд “дагалдах бичиг чухал үүрэгтэй ба тус дагалдах бичигт илгээгчийн оруулсан мэдээлэл буруу, дутуу эсхүл зааварт зааснаас өөр газарт бичигдсэн тохиолдолд тээвэрлэгчид хохирол учирвал түүнд учирсан бүхий л зардал, алдагдал эсхүл хохирлыг илгээгч хариуцна” гэж тус тус заажээ.

Гэрээний үүрэгтэй холбоотойгоор илгээгч нь тээвэрлэлт хийгдэх явцад тээвэрлэгчид заавал ачаа, тээвэрт холбогдох сав баглаа боодол, тэмдэглэгээний шаардлага хангагдсан, холбогдох баримт бичиг (дагалдах баримт, бичиг), мэдээллийг үнэн зөвөөр, бүрэн гүйцэд бүрдүүлж өгөх үүрэг хүлээдэг. Үүнтэй холбоотой онцлог зохицуулалт нь илгээгч нь дээрх нөхцөл байдалд гэм буруугүй байсан ч тээвэрлэгчид учирсан, хохирол, гарсан зардлыг хариуцах явдал юм.

Ийнхүү тээвэрлэгч үүссэн хохирол, учирсан гэм хорын хохирлыг шаардах эрхтэй байгаа нь илгээгчид тээвэрлэлтийг зохион байгуулахаас бусад тээвэрлэлттэй холбоотой бүхий л үйл ажиллагааны хувьд бүрэн хариуцлага ногдуулж байна гэж дүгнэх боломжтой.

Түүнчлэн тээвэрлэлтийн гэрээ болон тээвэр зуучийн гэрээнд илгээгч нь тухайн ачаа тээврийг аюултай ачаа тээвэр болохыг заавал бичгээр мэдэгдэх шаардлагатай. Хэрэв



тээвэрлэгчид мэдэгдээгүй тохиолдолд тээврийн гэрээний тээвэрлэгч нь “Илгээгчид хохирлыг нөхөн төлөлгүйгээр аюултай барааг буулгах, хадгалах, буцааж тээвэрлэх, шаардлагатай бол устгах эсвэл аюулгүй болгох эрхтэй” байх онцлог зохицуулалт үйлчилдэг.

**БНФУ-ын эрх зүйн зохицуулалтын тухайд:** Франц Улсын Иргэний хуульд Монгол Улсын иргэний хуульд заасантай адил тээвэрлэлтийн гэрээ, илгээмжийн гэрээ, худалдааны зуучлагч (төлөөлөгч), комиссыг ялгамжтай зохицуулаагүй, Иргэний хуулийн 1779 дүгээр зүйлд “тээвэрлэгчийг хөлслөх (түрээслэх)” гэрээний төрөл нь ажил, үйлчилгээ түрээсийн гэрээний нэг тусгай төрөл байхаар зохицуулсан онцлогтой. Харин Худалдааны хуульд зуучлагч (худалдааны төлөөлөгч)-ийн төрлийг ерөнхий байдлаар, тээвэр зуучийн гэрээний талаар дэлгэрэнгүй зохицуулсан байна.

Дээрх хоёр төрлийн гэрээний ялгаа нь тухайн этгээд хэний нэрийн өмнөөс, хэнийг төлөөлж эрх зүйн харилцаанд оролцож байгааг шалгуур болгосон, тухайлбал зуучлагчийн хувьд төлөөлүүлэгчийн нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулж чиг үүрэг хэрэгжүүлэх бол тээвэр зуучийн хувьд тэрээр хувь хүн бол өөрийн нэрийн өмнөөс, хуулийн этгээд бол компанийн нэрийн өмнөөс тухайн харилцаанд оролцож эрх, үүрэг хэрэгжүүлдэг.

Түүнчлэн тээвэрлэлтийн арга зам буюу авто зам, төмөр зам эсхүл усан замаар тээвэр хийхээс үл шалтгаалан Тээврийн хуульд харшлахгүй бол Худалдааны хуулиар тухайн харилцааг зохицуулна. Иймд тээвэрлэлтийн бичигтэй холбогдох зохицуулалт, бараа давагдашгүй хүчин зүйлийн улмаас устах, гэмтэх, алдагдах тохиолдолд хүлээлгэх хариуцлагын ерөнхий заалтыг баримтлах үндэслэлтэй. Харин Худалдааны хуульд үл хамаарах нөхцөл, маргаан үүссэн тохиолдолд Иргэний хуулийн ерөнхий ангийн үүргийн эрх зүйн зохицуулалт үйлчилнэ.

Ихэнх тохиолдолд тээвэр зуучийн харилцаанд оролцож байгаа талууд (3 тал оролцох: илгээгч, хүлээн авагч, тээвэрлэгч, 4 тал оролцох: илгээгч, хүлээн авагч, тээвэр зууч, жолооч) бичгээр гэрээ байгуулсан байх нь түгээмэл боловч гэрээ байгуулаагүй байх тохиолдол үүсэж болохоос гадна гэрээний заалт хууль зөрчсөн байх тохиолдол байх нь бий. Энэ тохиолдолд Франц Улсын Ерөнхий сайдын баталсан Тээврийн гэрээний жишиг гэрээний зохицуулалт үйлчлэх ба тус гэрээгээр талуудын хүлээх үүрэг, хариуцлагыг нарийвчлан дэлгэрэнгүй зохицуулжээ.

Тус гэрээнд зааснаар илгээгч (үүрэг гүйцэтгүүлэгч) нь барааг бэлдэж, баглаж, хаяглаж тээвэрлэлт болон хадгалах нөхцөл байдлыг тэсвэрлэх боломжтой болгон тээвэр зуучид (цаашилбал тээвэр зууч нь жолоочид) өгөх ба тэрээр баглаан дээр заавал тавигдах тэмдэг, маркийг нааж, тээвэр зуучид барааны шинжийн талаар

бичгээр эсхүл цахимаар анхааруулах үүрэгтэй байна. Харин тээвэр зууч нь илгээгчид ачаа илгээхээс өмнө мэдээлэл өгөх үүрэгтэй ба ийнхүү өгөх мэдээлэлд тээвэрлэлт дамжин өнгөрөх улс орнуудын дүрэм журам мөн тээвэрлэлттэй холбоотой гэрээ конвенцын талаар мэдээлэл хамаарахаар байна.

Иймд нэг талаас тээвэр зууч нь аливаа тээвэрлэлтийг саадгүй гүйцэтгэж захиалагчийн захиалсан барааг илгээгчээс хүлээн авч тээвэрлэлтийн харилцааг (жолоочтой хамтран) саадгүй гүйцэтгэх үүрэгтэй бол нөгөө талаас ийнхүү саадгүй гүйцэтгэхэд шаардагдах баримт бичгийг бүрдүүлэх үүргийг илгээгч хүлээнэ.

**Япон Улсын эрх зүйн зохицуулалтын тухайд:** Япон Улсын хувьд ачаа тээврийн гэрээ гэдэг нь тээвэрлэгч ачааг хариуцан тээвэрлэлт хийх гэрээг хэлэх бөгөөд ачаа тээврийн гэрээний оролцогчид нь нэг талаас ачаа илгээгч, нөгөө талаас тээвэрлэгч байна.



Ачааг хүлээн авагч нь гэрээний оролцогч тал болдоггүй.

Харин тээвэр зуучийн гэрээгээр зуучлагч нь тээвэрлэлтийн үйлчилгээ үзүүлэхдээ өөрийн нэрээр ачаа тээврийн зуучлалын үйлчилгээ үзүүлдгээрээ тээвэрлэлтийн гэрээнээс ялгаатай юм. Нөгөөтээгүүр, *худалдааны зуучлагч* гэж өөр этгээдүүдийн хоорондын аж ахуйн үйл ажиллагааны зуучлал явуулж байгаа этгээдийг хэлэх бол *комисс* нь өөрийн нэрээр үйлчлүүлэгчийн хөрөнгөөр бараа худалдан авах, худалдаалах үйл ажиллагаа эрхэлдэг этгээдийг хэлдэг байна.

Тээвэрлэлтийн гэрээний хувьд ачаа илгээгч нь тухайн ачааны төрөл зэрэг хуульд тусгайлан заасан мэдээллийг барааны дагалдах бичигт тэмдэглэж, тээвэрлэгчид гардуулж өгөх үүрэгтэй. Тээвэрлэгч нь бүрэн бус дагалдах бичгийн дагуу ачаа бараатай харьцаж, түүний үр дүнд ачаа гэмтэж, үрэгдсэн бол дагалдах бичгийг үндэслэн хохирлыг барагдуулах хариуцлагыг хүлээхгүйгээ маргаж болохоос гадна дагалдах бичигт үндэслэн өөрт учирсан хохирлын нөхөн төлбөрийг ачаа илгээгчээс шаардаж болдог.

Харин тээвэр зуучийн гэрээний хувьд зуучлагч нь ачааг хүлээж авснаас хүлээн авагчид ачааг хүлээлгэн өгөх хүртэл ачааг үрэгдүүлэх, гэмтээх, эсхүл үрэгдүүлсэн, гэмтээх шалтгаан нөхцөлийг үүсгэсэн, эсхүл бараа саатсан бол үүнээс учирсан хохирлыг барагдуулах хариуцлагыг хүлээнэ. Мөн ачаа бараа нь аюултай шинжийг агуулсан болон үнэ бүхий тохиолдолд заавал тээвэрлэгчид энэ тухай мэдээлэл өгөх үүргийг илгээгч нь хүлээдэг.



## НОМ ЗҮЙ

### Эрх зүйн эх сурвалж:

1. БНФУ-ын Иргэний хууль, 2016 он.
2. БНФУ-ын Худалдааны хууль, 2006 он.
3. БНФУ-ын Тээврийн хууль, 2023 он.
4. Варшавын конвенц, 1929 он.
5. Варшавын конвенцын нэмэлт өөрчлөлт, 1955 он.
6. Монгол Улсын Иргэний хууль, 2002 он.
7. Монтериалын конвенц, 1999 он.
8. Олон улс хоорондын авто замаар ачаа тээвэрлэх гэрээний тухай конвенц, 1956 он.
9. Олон улсын төмөр замын тээврийн тухай конвенц, 1999 он.
10. Олон улсын иргэний нисэхийн тухай Чикагогийн конвенц, 1944 он.
11. ХБНГУ-ын Арилжааны хууль, 1897 он.
12. ХБНГУ-ын Арилжааны хууль, 1900 он.
13. ХБНГУ-ын Төмөр замын тухай хууль, 2016 он.
14. ХБНГУ-ын Тээвэр Зуучийн Стандарт Нөхцөл, 2017 он.
15. Япон Улсын Далайд ачаа тээвэрлэх тухай хууль, 1899 он
16. Япон Улсын Арилжааны хууль, 1899 он.

### Монгол хэл дээрх эх сурвалж:

1. МУИС-ийн Хууль Зүйн Сургуулийн Хувийн эрх зүйн тэнхим, *ХБНГУ-ын Арилжааны (Худалдааны) хууль*. Анхны хэвлэл, 2018.
2. МУ-ын Иргэний Хууль (2002).
3. Г.Давааням, Г.Уянга, “Худалдааны зуучлагч, төлөөлөгч, комиссын гэрээний эрх зүйн зохицуулалт, түүний хэрэглээ” (2023), <https://legaldata.mn/b/1526>

### Гадаад хэл дээрх эх сурвалж, цахим хуудас:

1. Handelsgesetzbuch (1897) <https://www.gesetze-im-internet.de/hgb/BJNR002190897.html#BJNR002190897BJNG000200300>
2. Convention on the contract for the international carriage of goods by road (1956).
3. Uniform Rules Concerning the Contract of International Carriage of Goods by Rail (1999).
4. The Montreal Convention (1999).
5. German Freight Forwarders' Standard Terms and Conditions (2017) [https://www.gw-world.com/fileadmin/Country\\_Documents/DE\\_documents/Imprint-Memmingen/ADSp-2017-EN.pdf](https://www.gw-world.com/fileadmin/Country_Documents/DE_documents/Imprint-Memmingen/ADSp-2017-EN.pdf)
6. French Commercial Code (2000) [Article L132-5 - French Commercial Code - Légifrance \(legifrance.gouv.fr\)](https://www.legifrance.gouv.fr/Article/L132-5)
7. 最判昭和35年3月17日民集14卷3号451頁〔百選94事件〕。
8. 最判昭和45年4月21日判時593号87頁。



9. 近藤光男『現代商法入門（第8版）』（有斐閣アルマ・2009年）。
10. 北居 功・高田晴仁『民法とつながる商法総則・商行為法』（商事法務・2013年）。
11. 藤田勝利・工藤 聡—『Next教科書シリーズ（現代商取引法）』（弘文堂・2011年）。
12. Cour de cassation, civile, Chambre commerciale, 5 mai 2015, [Retard, pertes, avaries : quelle est la responsabilité du transporteur ? | Weblex](#)
13. [Intermédiaires de transport - Transport fluvial et professionnels de la voie d'eau \(developpement-durable.gouv.fr\)](#)
14. Contrat de transport de marchandises - Fiches d'orientation - juillet 2022 | Dalloz, [CAS - Central Authentication Service Login \(univ-paris1.fr\)](#)